

АГУУЛГА

Оршил	1
1. Төслийн товч танилцуулга	2
2. Байгаль орчны суурь судалгаа	5
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	8
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	9
А. Байгаль хамгаалах төлөвлөгөө	11
I. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөлт	11
II. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	13
III. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	13
IV. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	13
V. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	13
VI. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	14
VII. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	15
VIII. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	16
IX. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	16
В. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	16
С. Дүгнэлт	20

ХҮСНЭГТ

Хүснэгт: 2 Тусгай зөвшөөрөлтэй талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбицолууд	3
Хүснэгт: 3 Уурхайн барилга байгууламжуудын байршил, эзлэх талбай	4
Хүснэгт: 4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11
Хүснэгт: 5 Нийт нөхөн сэргээлтийн зардал, аргачлал	13
Хүснэгт: 6 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	14
Хүснэгт: 7 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөлт	15
Хүснэгт: 8 БОМТ-г хэрэгжилтийг тайлагнах хуваарь	16
Хүснэгт: 10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөлт	18
Хүснэгт: 11 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	20

ЗУРАГ

Зураг – 1 Төслийн талбайн байршилын тойм зураг	2
--	---

ОРШИЛ

“Минерал эксплорэйшн фандинг” ХХК нь Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын нутагт орших MV-019336 дугаарын тусгай зөвшөөрөл бүхий Баян-Овоогийн хүдрийн ордод 2010-2011 онд хайгуулын ажил гүйцэтгэн, ордын хүдрийн нөөцийг бодитой болон боломжтой зэргээр $B+C=1630.48$ мян.тн-оор улсын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээр хайлуур жоншны үнэ эрс өсч байгаа бөгөөд цаашид ч өсөх хандлагатай байгаа тул эрдэс баялгаа аж ахуйн эргэлтэд оруулж, улс орныхоо эдийн засгийн чадамжийг өсгөх таатай нөхцөл бүрдэж байгаа энэ боломжийг зүй зохистой ашиглах нь чухал юм.


Энэхүү төсөл хэрэгжсэнээр говийн бүсэд аж үйлдвэржилт эрчимжиж түүнийг дагаад бусад жижиг дунд үйлдвэрлэл байгуулагдснаар тухайн орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ, улсын төсвийн орлогыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлнэ.

2025 онд ил уурхайгаас нийт 176.05 мян.тн хүдэр олборлон ангилан ялгаж ФК-92 болон ФК-75 маркийн бүхэллэг жонш үйлдвэрлэх ба үлдэгдэл бага агуулгатай хүдрийг тусад нь овоолно. Далд уурхайд олборлолтын үйл ажиллагаа явуулахгүй ба зөвхөн Босоо ам №1, агааржуулалтын босоо ам, Налуу амуудыг нэвтрэхээр төлөвлөлөө.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ТӨСЛИЙН НЭР:	“Баян-Овоогийн хайлуур жоншны орд
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН НЭР: УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ: РЕГИСТРИЙН ДУГААР:	"Минериал Эксплорэйшн Фандинг" ХХК 9011848939 6995438
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ:	Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 1-р хороо Бага тойруу Жигжиджавын гудамж Хөдөлмөрийн ордон 9/1
АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:	MV-019336
ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ БАЙРШИЛ	Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумаас зүүн урд зүгт 50 километр зайд орших бөгөд байр зүйн зургийн L- 49-125 нэрэлбэрт байрлана.

Зураг: 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн байршилын тойм зураг /ТЭЗҮ/



Талбайн цаг уурын байдал: Судалгааны талбай нь эрс тэс уур амьсгалтай, VII сарын хамгийн их температурын дундаж +40 хэм, I сарын хамгийн бага температурын дундаж -30 хэм, жилийн дундаж тунадасжилт 82.4 мм. Олон жилийн дундажаас үзэхэд хамгийн их хур тунадас VIII сарын сүүлээр 5-7 мм байна. Өвөл унах хур тунадасны хэмжээ харилцан адилгүй, ихэнхдээ 1- 3 мм, зарим жил огт цасан бүрхүүл тогтдоггүй онцлогтой. Салхины жилийн дундаж хурд 2.6м/сек бөгөөд ерөнхий чиг баруун хойноос зүүн урагш чиглэлтэй байдаг. Жилийн ихэнх хоногуудад салхитай байдаг ба салхины хамгийн их хурд 20-30м/сек хүрнэ.

Уул зүй: Газрын гадаргуугийн хувьд далайн түвшнээс дээш 1100-1300 м өргөгдсөн хөндий хоолой, ухаа гүвээ, нам толгод зонхилно. Баянхошуу багийн төвийн хойд талаар зүүнээсээ баруун тийш сунасан 80-120 м харьцангуй өндөр мөргөцөгтэй Ханын хэц гэж нэрлэгддэг өргөгдөлд оршдог.

Хөрс ургамал: Гадаргуугийн хөрс нь Онгийн гол, Улаан нуурын ай сав нутгийн хэв шинж бүхий нимгэн говийн бор, хужир мараалаг хөрс, нутгийн хойд хэсгээр алаг тарлан элсэрхэг хөрс хөгжсөн. Ургамлын бүрхэвч тун ядмаг ган халуунд тэсвэртэй, шим тэжээл сайтай, жижиг навчит тачир ургамал голлож, хөндий сайруудад бага зэргийн зулзаган загийн төгөл, говийн бутлаг ургамалуудтай.

Гадаргуугийн ус: Баян-Овоогийн дүүрэг нь Төв Азийн гадагшаа урсгалгүй Онгийн гол Улаан нуурын ай савд багтдаг. Хагас цөлийн бүс зонхилох учир гадаргуугийн усан сүлжээ хөгжөөгүй мөн газар доорх усны нөөц багатай нутаг юм. Гуу, жалгууд нь хааяа тохиох хур тунадасны усаар үе үе тэжээгддэг бөгөөд хэрэв хур тунадасны хэмжээ ихэдвэл амархан үер болох магадлалтай.

Амьтны аймаг: Хэц хярыг дагаж аргал, янгир зэрэг ховор амьтад, тал нутгийн цагаан зээр, хар сүүлт, бөхөн зэрэг зэрлэг туурайтан сүрэглэн амьдардаг. Араатан амьтдаас шилүүс, үнэг, хярс, мануул, өмхий хүрэн байх ба мөлхөгчдөөс хонин ба могой гүрвэл хортой хоргүй могой төрөл бүрийн шавьж, хорхой байдаг. Жигүүртэн шувуудаас бүргэд элээ, хэрээ, шаазгай, болжмор, тагтаа байна. Ханын хэцийн дүүрэг нь нутгийн омгийн өндөр ашиг шимт хүрэн тэмээгээрээ алдартай.

Дэд бүтэц, хүн ам, эдийн засаг: Баян-Овоогийн орд орчмын хүн ам төвлөрсөн суурин газар нь Өмнөговь аймгийн Мандал-Овоо сум бөгөөд 6400 км² нутаг дэвсгэртэй сургууль, эмнэлэг, бүх төрлийн үйлчилгээний газруудтай засаг захиргааны анхан шатны нэгж бөгөөд 47700 мал сүрэгтэй 2011 оны хүн амын тооллогоор 1891 хүн бүртгэгдсэн төвийн эрчим хүчний шугамтай, бүх үүрэн холбооны сүлжээтэй. Ханын хэцийн талбайд зам харилцаа сайн хөгжөөгүй Даланзадгад хот болон Улаанбаатар хоттой шороон замаар холбогддог. Эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй бөгөөд тэмээн сүрэг, улаан ямааг өсгөн үржүүлдгээрээ аймагтаа алдартай. Баян-Овоогийн хайлуур жоншны ордоос баруун тийш 10 км-т Олон-Овоотын баяжуулах үйлдвэр байдаг.

Дэд бүтэц

Уурхайд дунджаар 200 гаруй хүн байнга ажиллаж амьдарна. Уурхайн ажиллагсдын тосгон Баян-Овоогийн уурхайгаас баруун зүгт 10км зайд орших бөгөөд 2009-2010 барьж байгуулсан байна. Уурхайн ажиллагсдын тосгонд уурхайн захиргааны байр хоолны газар, халуун ус, ахуй үйлчилгээний байр орон сууц, уурын зуух, засварын газар авто гараж, сэлбэг материалын агуулах зэрэг барилга байгууламжууд байна. Олон овоотын уурхайн тосгон 400- 450 хүн байрлуулах хүчин чадалтай.

Мөн далд уурхайн ойролцоо үйлдвэрийн барилга байгууламжууд шатах тослох материалын агуулах автомашины зогсоол, дулааны шугам сүлжээ зэргийг барихаар тусгав.

Үйлдвэрийн бүрэлдэхүүн нь тус ордоос хүдэр олборлох, боловсруулах, тээвэрлэх технологи болон түүний үйл ажиллагааг хэвийн явуулах, төлөвлөсөн хүчин чадлыг бүрэн эзэмших нөхцөл, үйл ажиллагаагаар тодорхойлогдоно. Уурхайн бүрэлдэхүүнд:

- Ил болон далд уурхай
- Баяжуулах үйлдвэр
- Цахилгаан хангамж
- Усан хангамж
- Ажиллагсдын тосгон болон уурхайн захиргаа
- Авто аж ахуй болон авто гараж
- Засварын газар
- Түлш дулаан хангамж
- Сэлбэг материалын агуулах
- Зам, тээвэр харилцаа холбоо

Уг төсөлд эдгээр барилга байгууламж болон үйлдвэрлэлийн зориулалттай объектуудыг сэндвичин угсармал хавтангаар байрьж байгуулна. Сэлбэг материалын болон тэсрэх материал тэсэлгээний хэрэгслэлийн агуулах зэрэгт чингэлэг ашиглах ба түүнийг тусгайлан норм стандартын дагуу бэлтгэн барьж байгуулах бөгөөд холбогдох зардлыг эдийн засгийн бүлгийн хөрөнгө оруулалтын зардалд шингээсэн болно.

Ил болон далд уурхай

Ил болон далд уурхайн хүрэн дэх хүдрийн нөөцийг ашиглалтанд бэлтгэх, тэдгээрийг олборлон баяжуулахад гол зорилго оршино. Ил уурхайн хувьд хөрс хуулалт болон хүдэр олборлолт, далд уурхайн үндсэн малталтуудыг нэвтрэх тэдгээрийг бүрэн бэхлэх тоноглох,

хөрсний чулуулгийн ба хүдрийн овоолгуудын суурийг бэлтгэж овоолго байгуулах зэрэг ажлуудыг урьдчилан тооцоолсон зураг төсөл, уурхайн төлөвлөлтийн ажлын дагуу гүйцэтгэнэ.

Ил уурхай: 2-р хүдрийн биетийн дээд хэсгийг +1250-р төвшин хүртэл ил уурхайгаар жилд 100.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтайгаар эхний 2 жилийн хугацаанд ашиглах юм.

Ил уурхай ажиллах хугацаанд далд уурхайн үндсэн болон бэлтгэл малталт нэвтрэлтийн ажил зэрэгцэн хийгдэнэ.

Далд уурхай: Далд уурхайн үндсэн малталт болох үндсэн босоо гол ам, агааржуулалтын босоо гол ам түүнчлэн квершлаг, штрек зэрэг малталтуудыг ашиглалтын 1 дэх жилээс буюу ил уурхайн уулын ажилтай зэрэгцэн явагдана.

Далд уурхай нь ашиглалтын 2 дахь жилээс эхлэн хүдэр гаргах бөгөөд жилд 200.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадлаар 8 жил ажиллана.

Цахилгаан хангамж

Ил, далд уурхай баяжуулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчдийг найдвартай эх үүсвэрээс хангахын тулд Өмнөговь аймгийн төв дэх 110/35/10кВ-ын Даланзадгад дэд станцаас 35кВ-ын өндөр хүчдэлийн агаарын шугам татаж төвийн эрчим хүчний нэгдсэн системээс цахилгаан эрчим хүчээр хангахаар төсөлд тусгаж байна.

Баяжуулах үйлдвэрийн дэргэд байрлах 4000кВА-гийн чадалтай ТМН-4000 маркийн хүчний трансформатор бүхий 35/10кВ-ын ерөнхий бууруулах дэд станцыг тэжээнэ.

Ажиллагсдын тосгон болон уурхайн захиргаа

Уурхайн ажиллагсдын тосгон Баян-Овоогийн уурхайгаас баруун зүгт 10км зайд орших бөгөөд 2009-2010 барьж байгуулсан байна. Уурхайн тосгонд захиргааны ажилтнуудын контороос гадна хоолны газар, халуун ус үйлдвэрийн дотоод холбоо, эмнэлэгийн цэг тус тус байна.

Баян-Овоогийн үйлдвэр, уурхайн ажилчдыг уг тосгонд байрлуулан, өглөө оройны ээлжийн ажилчдыг автобусаар зөөвөрлөхөөр төлөвлөсөн. Уг тосгон нь ажилчдын амрах, ажиллах нөхцөл боломжийг хангасан амралтын байрууд, халуун ус, хувцас угаалга, тоглоом, дасгалын байртай байна. Мөн нэг удаад 100 хүн хооллох хүчин чадалтай цайны газартай.

Хэдийгээр тус уурхайд тэргүүний дэвшилтэт технологитой, өндөр бүтээмжтэй тоног төхөөрөмж ажиллах боловч ажиллагсдын ажиллаж амьдрах тав тухтай нөхцлийг бүрдүүлэхгүйгээр хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, тавьсан зорилгодоо хүрэх боломжгүй юм. Ийм учраас уурхайн үйлдвэрийн болон технологийн ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх нь тэргүүн зэргийн зорилтын нэг болно. Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд дараах багц асуудлыг авч үзэх хэрэгтэй. Үүнд:

- Хөдөлмөрийн хөлс
- Орон сууцны нөхцөл
- Ахуйн үйлчилгээ

- Эмнэлэгийн үйлчилгээ

Эрүүл мэндийн урьдчилсан үзлэг хийх, зөвөлгөө өгөх, ойр зуурын өргөн хэрэглээний эмийн сан бүхий цэг, эмчийн хувьд уурхай дээр орон тооны 1 бага эмч ажиллана.

Уурхайн газрын дээрх барилга байгууламж, уурхайн удирдлагуудын контор буюу ажлын өрөө, нярадын байр буюу даалгавар авах өрөө, ажилчдын хувцас солих, усанд орох газар уурхайн ажиллагсдын цайны газар автомашины гараж, манаачийн байр, авто машины засварын газар зэрэг барилга байгууламж нь уурхайн тосгон дотор байрлана. Тэсрэх материал хадгалах агуулах, шатахуун түгээх станц нь уурхайн тосгон болон бусад барилга байгууламжаас аюулгүйн зайг тус тус харгалзан барьж байгуулна.

Зураг-3 тэсрэх материалын агуулах





Засварын газар

Уурхайн тоног төхөөрөмжийн засвар, техникийн үйлчилгээний газар нь уулын механик тоног төхөөрөмж, авто тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд урсгал засвар, техникийн үйлчилгээ хийх, ашиглалт засварын хэрэгцээнд зориулсан материал, сэлбэг, тос, түлш зэргийг хүлээн авах, хадгалах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

Тоног төхөөрөмжийн их засвар, зарим нарийн төвөгтэй эд ангийг сэргээх, бүрэн солих зэрэг ажлыг засварын дагнасан газраар буюу тоног төхөөрөмжийг нийлүүлсэн газрын засварын газраар гүйцэтгүүлэнэ. Засварын газар нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Уулын механик тоног төхөөрөмжийн агрегат ба автомашины засвар, техникийн үйлчилгээний хэсэг

- Механик цех
- Цахилгаан тоноглолын засварын хэсэг
- Шингэн түлшний резервуар, түгээх цэг
- Материал, сэлбэгийн агуулах

- Автомашины гараж

Эдгээр төхөөрөмжүүдийг сэндвичин барилгад байрлуулах боломжтой бөгөөд дэргэд нь нэгэн зэрэг 3-5 автомашин, утгуурт ачигч зэргийн засвар хийх боломжтой, зориулалтын зарим нэг тоног төхөөрөмжөөр тоноглогсон сэндвичин барилга барьж байгуулна.

Далд уурхайд ажиллах техник тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээг хийх зориулалт бүхий засварын газар нь босоо гол амны дэргэд байрлана. Далд уурхайн засварын газарт өргөх төхөөрөмж, токарь болон өрмийн цахилгаан суурь машин, гагнуурын багаж зэрэг байна. Уурхайн газрын дээр ажиллах техник тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдлыг хангаж тэдгээрийн засвар үйлчилгээг ХАБЭА-н нэгдсэн дүрмийн дагуу зориулалтын байр болон зогсоолын газарт цаг алдалгүй хийх шаардлагатай байдаг. Газрын дор байрлах засварын газрыг дараах тоног төхөөрөмжүүдээр бүрэн тоноглогсон байх шаардлагатай.

- Өргөх төхөөрөмж, слесарын бусад багаж хэрэгслэлүүд
- Гагнуурын аппарат болон бусад багаж хэрэгслэлүүд

Хүнд машин механизмын засвар механикийн цех: Уурхайн тосгоны дэргэд байрлах хүнд машин механизмын тоног төхөөрөмжийг засварлах, хуучин сэлбэгийг сэргээн засварлах, урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэхэд оршино. Нэгдсэн засварын цехийн тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээнд шаардагдах тоног төхөөрөмжийг иж бүрнээр сонгосон байна. Үүнд:

- Токорын суурь машин 16к20 маркийн
- Өндөр даралтын шланк базагч DSG-2508 маркийн
- Өрмийн суурь машин 2Х125 75 маркийн
- Суурин гидро насос 34SM-LIОН-Т маркийн
- Суурин точил ПД-22маркийн
- Суурин точил S1ST-200 маркийн
- Аккумулятор цэнэглэгч ВСА-5А маркийн
- Плазм зүсэгч CUT-100 маркийн
- Гагнуурын аппарат ZX7-630 маркийн
- Гагнуурын аппарат ZX7-500 маркийн
- Хийн гагнуур ПГУ-3-02 маркийн
- Керосин зүсүүр РК-62 маркийн тус тус байна.

Түлш дулаан хангамж

Баян Овоогийн ил болон далд уурхай, хүдэр баяжуулах үйлдвэр нь жилд 270-330 хоног ажиллах ба өвлийн улиралд ажиллагсдын тосгон болон уурхайн захиргаа, засварын газар зэрэг барилга байгууламжийг нам даралтын бага оврын уурын зуухаар эдгээр газруудыг дулаанаар хангана.

Уурын зуухны ажиллах сар нь зөвхөн хүйтний улиралд ажиллах буюу 11-р сарын 1-нээс 4-р сарын сүүл хүртэл буюу 6 сарын хугацаанд ажиллана. Уурын зуухны сарын хэрэглээнд 5тн нүүрс түлэх шаардлагатай гэж үзвэл жилд буюу 6 сарын хугацаанд 50тн нүүрс хэрэглэнэ.

Шаардлагатай нүүрсийг Таван толгойн нүүрсний ордоос түрээсийн автотээврээр 50тн нүүрс худалдаж авахаар төсөлд тусгаж байна.

Сэлбэг материалын агуулах

Тус уурхайн тэсрэх бодисын болон тэсэлгээний хэрэгслийн агуулах нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хил дотор уурхайн баруун хойд талд 1-1.5км аюулгүй зайд байрлана. Тус агуулахыг 2017 онд барьж 2018 онд ашиглалтад оруулаад байна.

Тэсрэх бодис хадгалах 40 тоннын багтаамжтай 2 ширхэг контейнер, тэсэлгээний хэрэгсэл хадгалах зориулалт бүхий 20 тоннын 2ш контейнер агуулах тус тус байна.

Сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийн агуулахыг 10-20 тоннын багтаамжтай контейнер ашиглан байгуулсан.

Шатах тослох материалын агуулах нь торон хашаагаар хүрээлэгдсэн баяжуулах үйлдвэрийн баруун талд үйлдвэрлэлийн талбайд баригдсан. Энд 20-40тн багтаамжтай төмөр торхтой тосолгооны материал, тос болон уурхайн 30 хоногийн ажлыг хангах хэрэгцээний түлшний багтаамж бүхий ёмкость байрлана.

Зам тээвэр, харилцаа холбоо

Тус орд нь ойролцоох сум суурин газруудтай ердийн хээрийн орон нутгийн чанартай шороон замаар холбогдоно.

Үйлдвэрийн болон уурхайн дотоод замууд нь байнгын усалгаа арчилгаатай уурхайн зориулалтай сайжруулсан шороон зам байна. Харин ил болон далд уурхайгаас олборлосон хүдрийг баяжуулах үйлдвэрт баяжуулж боловсруулан гарсан баяжмалыг Шивээ хүрэн хилийн боомт хүртэл авто тээврээр тээвэрлэн, БНХАУ-д экспортлохоор төсөлд тусгалаа.

Төслийн талбай нь Улаанбаатар хотоос 520 км, Өмнөговь аймгийн Даланзадгад хотоос 90 км, Мандал-Овоо сумын төвөөс 50 км зайд орших бөгөөд авто замын сүлжээ нь засмал зам болон энгийн шороон замаар холбогддог. Уурхай болон хотхоны хоорондох зам нь сайжруулсан шороон зам ба автогрейдерээр байнга хусаж цэвэрлэж байна. Уурхайн үйлдвэрлэлийн талбайд 30 тн-ын даацтай өөрөө буулгагч автосамосвалаар далд уурхайгаас баяжуулах үйлдвэрийн хүдэр хүлээн авах талбай хүртэлх зам, мөн уурхайн бусад хэсгүүдэд очих уурхайн дотоод тээврийн замуудыг 8 м-ийн өргөнтэй, туслах замууд 5 м-ийн өргөнтэй байхаар тооцсон.

Мандал-Овоо сум нь төвийн эрчим хүчний 35 кВт шугаманд холбогдсон бөгөөд үүрэн телефоны Мобиком, Юнител, Жи Мобайл, Скайтелийн сүлжээ болон Мобиком,

Юнителийн сансрын холбооны интернет 2011 онд тавигдсан. Уурхайн ойролцоох төв суурин газрууд нь харилцаа холбоо дунд зэрэг хөгжсөн бүсэд хамрагдана. Уг район нь хүн ам маш сийрэг суурьшилтай, өөрөөр хэлбэл 1км^2 талбайд 0.5 хүн ногдох бөгөөд нутгийн уугуул иргэд нь голчлон мал аж ахуй эрхэлдэг цөөн хэсэг нь тухайн орон нутагт ажиллаж байгаа уурхайнуудад ажилладаг.



2. БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ СУДАЛГАА

Төсөл хэрэгжих орчны цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтийг Өмнөговь аймгийн Мандал-овоо сумын цаг уурын “Мандал-Овоо” харуулын 2017 оны жилийн мэдээний үндсэн дээр тодорхойлсон болно.

Агаарын температур: Агаар мандлын дулааны горим бол агаар мандал дахь температурын хуваарилалт, хувьсал өөрчлөлтийн явцаар тодорхойлогдох бөгөөд энэ нь тухайн газар нутгийн уур амьсгалын үндсэн элемент болж агаар, хүрээлэн буй орчны хоорондох дулааны солилцоогоор илэрдэг зүй тогтолтой. Мандал-Овоо сумын 2017 оны агаарын жилийн дундаж температур нутгийн ихэнх газраар өвлийн улиралд -9.7°C - 17.1°C , зуны улиралд 14.5°C - 22.1°C байдаг байна.




График 1.Манда-овоо сумын 2017 оны агаарын хамгийн их, бага температур

Хөрсний температур: Манда-Овоо сумын хөрсний гадаргын температурын 2017 оны байдлаар хамгийн их халсан сар 7-р сард 28.4 градус дулаан, хамгийн их хүйтэрч хөлддөг -12,7 градус Манда-Овоо харуул станц/ хүйтэрч байсан. Хөлдөлтийн гүн жил бүр харилцан адилгүй байдаг ба дунджаар 200 см хүрч хөлддөг. 11 дүгээр сарын I-10 хоногт хөрс хөлдөж эхлэдэг бөгөөд 2 дугаар сарын I-10 хоногт бүрэн хөлдөж дуусдаг. Хавар 3 дугаар сарын III-10 хоногоос хөрсний өнгөн үе гэсэж, 4 дүгээр сарын II-10 хоногоос 5 дугаар сарын II-10 хоногийн хооронд хөрс бүрэн гэсэж дуусдаг.




График 2.Манда-Овоо сумын хөрсний дундаж температур

Хур тунадас: Хур тунадас бол тус орны нутаг дэвсгэрийн уур амьсгалын нөхцөлийг илэрхийлэгч чухал хүчин зүйлийн нэг юм. Тунадасны хуваарилалт газар нутгийн өндөр, ялангуяа чийг авч яваа агаарын урсгалын замд тохиолддог уулс яаж байрласнаас ихээхэн шалтгаалдаг. Мандал-Оюуоо сумын хувьд хур тунадасны 2017 оны жилийн хүйтний улирлын хур тунадасны дундаж хэмжээ 0.3-1.6 мм, дулааны улирлын хур тунадасны дулааны хэмжээ 2.5-5.3 мм байна. Нийт унах хур тунадасны ихэнх дулааны улиралд унадаг. Үүнээс харахад хур тунадас олон жилийн дундажаас бага байна.




График 3. Мандал-Овоо сумын дундаж хур тунадасны нийлбэр

Агаарын даралт ба салхи: Агаарын даралт газрын гадарга дээр жигд бус хуваарилагдсанаас болж салхи буюу агаарын урсгал үүсч тэр нь дулаан хүйтэн, чийг, цас, бороо гэх мэт олон үзэгдлийг нэг газраас нөгөөд зөөж байдгийн хувьд агаарын даралт уур амьсгалын чухал элемент болдог. Сумын хувьд монголын хамгийн их салхитай байдаг нутаг юм. Энэ нь манай орны хойд ба өмнөд зүгийн агаарын урсгалын хооронд оршдог учраас их салхитай байдаг. Агаарын 1 дүгээр сарын дундаж даралт нутгийн баруун хойд хэсгээр 846-850 гПа, бусад нутгаар 844- 846гПа. Харин 7 сарын байдлаар 842-844 гПа байдаг байна. Салхины хамгийн их хурд 6-8 м/с, салхигүй өдрийн тоо 26, 15 м/с ба түүнээс хүчтэй салхитай өдрийн тоо жилд 30, цасан шуургатай өдрийн тоо жилд 10-аас дээш, явган шуургатай өдрийн тоо жилд 10, шороон шуургатай өдрийн тоо жилд 30 байдаг байна. Салхины хамгийн их хурд 25 м/с хүрч байсан.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Агаарын чанарт нөлөөлөх гол сөрөг нөлөөлөл нь дараахи эх үүсвэрүүдээс бүрдэнэ.

- Баяжуулах үйлдвэрийн хүдэр нунтаглах бутлах хэсэг
- Тэсэлгээний үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт
- Ашиглалт, олборлолтын хэсэг хүнд машин механизмийн тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас үүсэн тоосжилт

Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Баян-Овоогийн жоншны уурхайн талбай нь Онгийн гол Улаан нуурын сав газарт хамаарах бөгөөд цөлөрхөг хээрийн бүс зонхилох учир байнгын урсацтай гол горхи байхгүй. Харин түр урсацтай хуурай сайрууд уурхайн талбайг хөндлөн огтолно. Эдгээр сайруудад зун намрын эрчимшил хур борооны үед түр урсац үүсдэг. Иймд уурхайг олборлох үйл ажиллагааны улмаас гадаргын усанд шууд нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй. Төслийн үйл ажиллагаанаас газрын доорхи усанд үзүүлж болзошгүй нөлөөлөлд усыг ил болон далд уурхай, уурхайн хотхон баяжуулах үйлдвэр зэрэгт газрын доорхи усыг ашигласанаар усны түвшин буурах нөлөөлөлд орж болзошгүй.

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэхь тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасана.

Уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсч тоосжилт үүсгэнэ. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдож болзошгүй байна.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Минерал эксплорэйшн фандинг” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаварыг тогтмол хянах, илрүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, нэмэгдүүлэх зорилт тавьж үйл ажиллагаагаа эхлүүлж байгаа болно.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2019 онд Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгосон. Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж ажиллана.

2025 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараахи гол зорилтуудыг тавьж ажиллахаар төлөвлөж байна. Үүнд:

- Байгууллагын байгаль орчны бодлого дотоод журамыг нийт ажилтан албан хаагчидад танилцуулж үйл ажиллагааны бүхий л үе шатанд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бага байлгах бодлогыг хэвшүүлэх.
- Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг сайжруулж, түүнд нутгийн иргэдийг оролцоог хангах, дэмжих ажлыг үргэлжүүлэн хийх.
- Нөхөн сэргээлтийн ажлын үр дүн бүтээмжийг сайжруулан биологийн болон техникийн нөхөн сэргээлтийг холбогдох стандартад нийцүүлэн чанартай хийж гүйцэтгэх.
- Орон нутгийн иргэн албан хаагчидад байгаль орчны чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлыг танилцуулж нээлттэй хамтын ажилгааг хөгжүүлэх

Эрх зүйн үндэслэл

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагварыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 31.4 дэх заалт болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9.6, 9.7 дахь заалт, 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн Байгаль орчин аялал жуулчлалын сайдын А-618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах, батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн, 2025 оны Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөлт зэргийг удирдлага болгов.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтоо биелүүлэхийн тулд Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, тухайн жилийн байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг барьж ажиллах болно.

А. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний салшгүй нэг хэсэг бол байгаль хамгаалах төлөвлөгөө бөгөөд энэ төслийн үйл ажиллагааны явцад хүрээлэн буй орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, үүссэн нөлөөллийг бууруулахад барьж ажиллах төлөвлөгөө болно. Төлөвлөгөөний хэрэгжилтэд “Байгаль орчныг хамгаалах тухай”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай”, “Усны тухай”, “Газрын тухай зэрэг хууль тогтгоомжинд заасны дагуу төрийн захиргааны төв орон нутгийн байгууллагууд хяналт тавьж хэрэгжилтийг хангуулна.

I. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт-4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
АГААР МАНДАЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРИЛГАХ ЧИГЛЭЛЭЭРАВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ				
Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Зам, талбайн усалгааны хэмжээ, норм, горимыг сар, улирлаар оновчтой тогтоох;	Ажиллах нийт хугацаанд Талбайн хэмжээнд	ҮАЗ	Ажиллах хугацаанд
	Тэсэлгээний үеийн тоосжилт бууруулах, салхины чиглэл хурдтай уялдуулж зохицуулах, усан дэр ашиглах	- Ажиллах нийт хугацаанд - Талбайн хэмжээнд	ҮАЗ	Ажиллах хугацаанд
	Технологийн зам талбайг засаж сайжруулах замын тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Олборлолтын талбайн хэмжээнд	2.0	
	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах;	Ажиллах нийт хугацаанд Бүх хүнд механизм	ҮАЗ	Ажиллах хугацаанд
	Тоосжилтоос урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа явуулах;	Ажиллах нийт хугацаанд Нийт ажилчидад	0.5	Ажиллах хугацаанд
Дүн			2.5	

УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРИЛГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Ахуйн хаягдал, шатах, тослох материал ба бусад хаягдлаас бага гүний уст давхарга болон хөрс ургамал бохирдох	Тоосжилт дарах үйл ажиллагаанд ашиглах гэж байгаа усыг MNS-4943-2015 стандартын шаардлагад нийцэж байгаа эсхийг тогтмол хянах, шинжилгээнд хамруулах	төлөвлөгөөт онд	ҮАЗ	1-2р улиралд
	Ажилчид болон уурхайн нөлөөллийн бүсэд байх ард иргэдийн унд ахуйн хэрэгцээний усны чанарт хяналт тавьж ажиллах	Ажиллах нийт хугацаанд - Боломжтой 2 газарт	1.0	2-3р улиралд

Дүн

1.0

ХӨРСӨН БҮРХЭВЧ, ГАДАРГЫН ХЭЛБЭР ТӨРХӨНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРИЛГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Ахуйн хаягдал, шатах, тослох материал ба бусад хаягдлаас хөрс бохирдох	Бохирдсон хөрсийг цэвэрлэх, ариутгах арга хэмжээ авч байх	- Ажиллах нийт хугацаанд - Тухай бүрт	0.5	Ажиллах хугацаанд
	Усгүйжүүлэх технологи алдагдснаас бохирдолт, бохирдсон урсац үүсэх улмаар бохирдолт бий болохоос хамгаалах арга хэмжээ авах	- Ажиллах нийт хугацаанд - Тухай бүрт	-	Ажиллах хугацаанд
Автомашины тээвэрлэлтийн үед осол аваарь гарах	Автомашины хурдыг боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах	- Ажиллах нийт хугацаанд - Тухай бүрт	0.5	Ажиллах хугацаанд

Дүн

1.0

II. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төлөвлөгөөт онд тус талбайд 1.0 га талбайд техникийн нөхөн сэргээлт гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна. Уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалан тус онд биологийн нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэхгүй болно. Бид техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн талбайд дараа онд нь биологийн нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Дээрхи нөхөн сэргээлтийн ажлуудыг холбогдох стандартын дагуу гүйцэтгэх болно. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS-5917-2008, Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ерөнхий шаардлага MNS-5918-2008

Хүснэгт 5. Нийт нөхөн сэргээлтийн зардал, аргачлал / сая төгрөг/

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт өртөг (сая.төг)	Баримтлах стандарт, аргачлал
Техникийн нөхөн сэргээлт	Дүүргэлт	1.0 га талбайд дүүргэлт гүйцэтгэх	ҮАЗ	MNS-5917-2008,
Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрс хамгаалах	Шимт хөрсний овоолго үүсгэх		
Нийт				

III. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус арга хэмжээг Өмнөговь аймгийн Байгаль орчны газраас гаргасан чиглэл зөвлөмжийн хүрээнд орон нутгийн саналд хийж гүйцэтгэх бөгөөд тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд 500 ширхэг мод тариалахаар төлөвлөж байна.

IV. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус арга хэмжээ нь төсөлд хамааралгүй болно.

V. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус арга хэмжээ нь төсөлд хамааралгүй болно. Бид үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээнд нэн тэргүүний ач холбогдол өгч холбогдох арга хэмжээний хүрээнд арга хэмжээ авч ажиллах болно.

VI. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, химийн бодисын эрсдэлийн үнэлгээний дүнд тогтоосон аюултай болон хортой химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгана.

Хүснэгт 6. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Цаг агаарын урьдчилсан мэдээлэлд тулгуурлан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг байгальд ээлтэйгээр зохицуулах	Төслийн нийт арга хэмжээнд	0.3	Жилд 1 удаа
	Сургалт сурталчилгаа хийх	Үйл ажиллагаа үргэлжлэх нийт хугацаанд	0.2	Жилд 1 удаа
Нийт зардал	0.5			

VII. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 онд Баян-Овоо уурхай нь олборлолт, баяжуулалтын үйл ажиллагаа явуулахдаа “Олон-Овоот” уурхайн тосгонд байрлан ажиллах тул ахуйн хог хаягдал ашиглалтын талбайд үүсэхгүй. Иймд тус онд тухайн арга хэмжээний чиглэлээр дараахи ажлуудыг гүйцэтгэнэ.

- Талбайн орчимд нөхөн сэргээлтийн ажил дууссаны дараа хог хаягдал түүх
- Нөхөн сэргээлтэд ашиглагдаж буй техникээс гарах тос тосолгооний хаягдалыг зохистой хадаглаж тээвэрлэх
- Төслийн талбайд ажиллаж буй ажилчидад хог хаягдалыг ангилан зөвшөөрөгдсөн талбайд хуримтлуулах талаар мэдээлэл олгох

VIII. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхай нь үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцан ажиллана.

Хүснэгт 7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	2025 он	Зардал, төг	Хариуцагч
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Төслийн хугацаанд	Дотоод төлөвлөлтөөр	Удирдлага
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.	5 8 саруудад	0.5 сая/төгрөг	Удирдлага
3	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон Мандал-овоо сумын ЗДТГ-т хүргэн өгч байх	11 сард	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	Удирдлага
4	Газрын хянан баталгааны ажил гүйцэтгүүлэх	Төслийн хугацаанд	8.0 сая төгрөг	Удирдлага
5	Сургалт мэдээлэлээр ажилчидад хүрээлэн буй орчны мэдээлэл олгох.	Төслийн хугацаанд	2.0	Удирдлага
Нийт зардал			10.5 сая төгрөг	

IX. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь тухайн төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчин, оршин суугчдын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийн бууруулах, хяналт тавих зэрэг арга хэмжээ орох тул тухайн онд ямар арга хэмжээ

төлөвлөж ажиллахыг орон нутгийн оршин суугчид, оролцогч талуудын оролцоо зайлшгүй байх ёстой зүйл юм.

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ. Мөн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрт оршин суугчдад БОМТ-ний төлөвлөлт хэрэгжилтийн талаар, үйлдвэрлэлийн орчмын эрсдэлийн биологийн нөхөн сэргээлтийн талаар мэдээлэл өгч ажиллана.

Хүснэгт-8 БОМТ-г хэрэгжилтийг тайлагнах хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Төслийн талбайн орчимд	Танилцуулга санал авах	нөхөн сэргээлтийн төлөвлөлт тайлан	Төслийн хугацаанд	БОХ арга хэмжээний тайлан ирэх оны төлөвлөгөөний төсөл	Талбайн орчимд
Захирамжаар томиологдсон комиссын гишүүд	Комиссын шалгалт, хурал	Тайлангийн хэрэгжилтийн шалгалт	12-р сарын 1 дотор		Уурхай
БОАЖЯ	Албан бичиг	Тайлан Ирэх оны төлөвлөгөө	12-р сарын 31		Улаанбаатар хот

В. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний салшгүй нэг хэсэг бөгөөд төслийн үйл ажиллагаа байгаль орчин, нутгийн иргэд, ажиллагсадын амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, хүрээлэн буй орчны бүрдлүүд бүр дээр холбогдох итгэмжлэгдсэн лабораториудаар хяналт шинжилгээг хийлгэж стандартын шаардлагыг хангаж байгаа эсэх талаар анализ хийж зөрчил илэрсэн тохиолдолд бууруулах, арилгах арга хэмжээ авах шаардлагатай.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох

үзүүлэлтүүд, төсөл хэрэгжих орчинд амьдардаг, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн амьжиргаа, нийгмийн болон эрүүл мэндийн байдлыг илтгэх гол үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамжийг тодорхойлон оруулна. Мөн уг ажлын хэмжээг хэмжих нэгж, нэгжийн үнэ, нийт зардал, баримтлах стандарт, аргазүй, аргачлалыг тусгана.

Орчны хяналт шинжилгээний ажлыг жил бүрийн байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайланд оруулж байгаль орчны асуудал эрхэлсэн орон нутгийн болон төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана. Мөн байгууллагын дотоодын хяналтыг хэрэгжүүлэх, төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөөллийг тухай бүр хянах, цаг алдалгүй хариу арга хэмжээ авах зорилгоор байгаль орчны асуудал хариуцсан ажилтан улирал тутам хяналт шинжилгээний дүн мэдээгээр тайлан бэлтгэж, зохих удирдлагадаа тайлагнана. Бид тус онд хөтөлбөрийн хүрээнд Байгаль орчны зөвлөх үйлчилгээний мэргэжилийн байгуулалгатай хамтран ажиллаж тус хөтөлбөрийн суурь үзүүлэлт хатуу цэгүүдийг тогтоож хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж зэргийг гаргуулан ажиллана.

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээний дээж	Хяналт шинжилгээний үзүүлэлт	2025 оны хяналт шинжилгээний хэлбэр, зардал	Хяналт шинжилгээ явуулах хугацаа	жилийн хяналт шинжилгээний зардал	Хяналт шинжилгээ явуулах байршил	Хяналт шинжилгээ хийх багаж, холбогдох стандарт
1	Агаар	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж /Pm10, pm2.5, нийт тос/, NO ₂ , SO ₂ CO -ын агууламж, орчны дуу чимээ	Агаарын шинжилгээний 3 цэгт жилд 2 удаа хэмжилт хийлгэнэ. (нэг цэгт 20 минут, автомат анализатораар хэмжилт хийхээр тооцсон) 1 цэгт нэг удаагийн хэмжилт -50,000*2 удаа*3 / автомат анализатар хэмжигч тухайн байгууллагын ажлын хөлс -500,000/ “Булган аймаг ЦУОХШГазар	5 сар 9 сар	2500000	Уурхайн каррьер, Уурхайн зам, Ажилчдын хотхон Тэсрэх материалын агуулах	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар-хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007
2	Ус	Ажилчдын унд ахуйд ашигладаг усыг бактериологи болон ундны усны ерөнхий шаардлага, цэврийн болон	Унд ахуйн ус-1 ширхэг Бактериологи - 85 210 төгрөг Усны химийн ерөнхий шинжилгээ – 43 000 төгрөг Хүнд металл	5 сар 9 сар	2244420	Унд ахуйн усны гүний худаг,	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус, Ерөнхий шаардлага MNS 4943:2008, Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005,

		бохирын нуурын усыг					Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага
3	Хөрс	Хөрсний агрохими болон хүнд металлын шинжилгээ хийлгэх мөн тухайн газар дээр хөрсний температур хэмжих	Шимт хөрсний овоолго- 2 ширхэг Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай – 2 ширхэг Засварын талбай-1 ширхэг Шатахуун түгээх газар -1 ширхэг Хотхон-1 Тэсрэх материалын агуулах-1 Нийт 8 ширхэг * 80 000 төгрөг = 640 000 * 2 = 1 280 000 төгрөг “	5сар 9 сар	3280000	Уурхайн шимт хөрсний овоолго, ахуйн бохир усны хаягдал орчимд,нөхө н сэргээсэн талбай, эвдрээгүй газар, ,	MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр. төрөл MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох MNS2305-94 Дээж авах. савлах. тээвэрлэх. хадгалах журам MNS(ISO) 4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх
4	Ургамал	Ургамалын нөмрөгийн тархац үйл ажиллагаанаас үзүүлж буй сөрөг нөлөөллийн эрчимжилт зэргийг тогтоох	Хотхон , ашиглалтын талбай тэсрэх материалын агуулах тээвэрлэлтийн зам , ШТС хог хаягдалын цэг орчим ургамалын судалгаа бичиглэл хийлгэх.	5сар 9 сар	1500000		

БАЯН-ОВООГИЙН ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025

5	Амьтан	Уурхайн үйл ажиллагааны улмаас талбайн орчимд амьтаны аймагт үзүүлж буй нөлөөллийг судлах	9 сар	2200000	Талбайн үйл ажиллагаанаас мөлхөгч болон хөхтөн амьтанд үзүүлж буй нөлөөллийг судлах
	Нийт		Нийт жилд /1 жилд/=11720000		

\

Хүснэгт-11.2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт төсөв

№	Төлөвлөгөөнүүд	Төсөв сая.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4.5
2	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	0.5
3	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
4	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	10.5
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	11.72
6	Биологийн олон янз байдал дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр	5.0
	Нийт	32.364

С. ДҮГНЭЛТ

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах нөхөн сэргээх зардалд 32.364 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн . Мөн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бага түвшинд байлгах, нөхөн сэргээлтийн ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч ажиллах, нөхөн сэргээлт гүйцэтгэсэн талбайн ач холбогдолын талаар оршин суугчидад мэдээлэл олгож нөхөн сэргээсэн талбайн үр дүнг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллана.

Бид уг төлөвлөгөөг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журамын дагуу боловсруулав.



НИЙСЛЭЛИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ МАГАДЛАЛ

2024 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 210/МА2024/01892

Улаанбаатар хот

“Зөв зүг” ХХК-ийн нэхэмжлэлтэй
иргэний хэргийн тухай

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ч.Цэнд даргалж, шүүгч Д.Дэлгэрцэцэг, Д.Золзаяа нарын бүрэлдэхүүнтэй тус шүүхийн танхимд хийсэн шүүх хуралдаанаар

Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 181/ШШ2024/02980 дугаар шийдвэртэй

Нэхэмжлэгч “Зөв зүг” ХХК-ийн нэхэмжлэлтэй

Хариуцагч Банкны төлбөр барагдуулах газарт холбогдох

2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 1/4071 дугаартай албан бичгээр MV-019336 дугаар ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газарт даалгасан ажиллагааг хүчингүй болгуулах, тусгай зөвшөөрлийг битүүмжлэлээс чөлөөлөхийг даалгах тухай иргэний хэргийг нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нарын гаргасан давж заалдах гомдлыг үндэслэн шүүгч Д.Золзаяагийн илтгэснээр хянан хэлэлцэв.

Шүүх хуралдаанд: Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Анастасия, нэхэмжлэгчийн өмгөөлөгч А.Цогтбаяр, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Б.Сарантуяа нар оролцов.

ТОДОРХОЙЛОХ нь:

1. Нэхэмжлэгчийн нэхэмжлэл, тайлбарын агуулга:

1.1. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 101/ШШ2016/01139 дугаар шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шүүхийн 2016 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 689 дүгээр магадлал, Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2016 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 001/ХТ2016/00853 дугаар тогтоолоор “Олон овоот гоулд” ХХК-аас 45,491,354,932 төгрөг гаргуулж “Хадгаламж банк” ХХК дахь Банкны эрх хүлээн авагчид олгохоор шийдвэрлэсэн. Дээрх шүүхийн шийдвэрийн дагуу “Олон овоот гоулд” ХХК-ийн үүргийн гүйцэтгэлд барьцаалсан ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдээр үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Банкны өр барагдуулах газар нийт 8 тусгай зөвшөөрлийг төлбөр авагчид шилжүүлэх үйл ажиллагааг явуулахдаа манай компанийн MV-019336 дугаар тусгай зөвшөөрлийг хамтад нь шилжүүлэх шийдвэр гаргасан нь “Зөв зүг” ХХК-ийн эрх ашгийг ноцтой зөрчсөн байна.

000007701

1.2. Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн 2013 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 1711 дүгээр захирамжаар нэхэмжлэгч Э.Сүрэнгийн нэхэмжилсэн 11,505,619 ам.доллар 34 цент төлбөрт хариуцагч "Олон овоот гоулд" ХХК нь өөрийн эзэмшлийн MV-017172 /одоогийн MV-019336/ дугаар тусгай зөвшөөрлийг шилжүүлснээр төлж барагдуулсанд тооцохоор харилцан тохиролцож эвлэрснийг баталж хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн. Шүүхийн шийдвэрийн дагуу Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж дээрх тусгай зөвшөөрлийг "Зөв зүг" ХХК-ийн эзэмшилд шилжүүлэн холбогдох бүртгэлийг Ашигт малтмалын газарт хийлгэсэн байдаг.

Иймд манай компанийн эзэмшлийн тусгай зөвшөөрлөөр үүргийн гүйцэтгэл хангуулах хууль зүйн үндэслэлгүй байх тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.3 дахь хэсэгт заасны дагуу 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 1/4071 дугаартай албан бичгээр Ашигт малтмал, газрын тосны газарт хандан манай компанийн MV-019336 дугаар ашиглалтын тусгай зөвшөөрлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3-т заасны дагуу шилжүүлэхийг даалгасан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгож өгнө үү. Мөн тусгай зөвшөөрлийг битүүмжлэлээс чөлөөлөхийг даалгах нэхэмжлэл гаргаж байна гэжээ.

2. Хариуцагчийн татгалзал, тайлбарын агуулга:

2.1. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж төлбөр төлөгч "Олон овоот гоулд" ХХК-ийн 100 хувийн хувьцаа эзэмшигч Г.Алтанд шүүхийн шийдвэр биелүүлэх мэдэгдлийг удаа дараа гардуулж шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг биелүүлэхийг мэдэгдсэн боловч шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй төлбөрийг төлөх талаар санаачилга гаргадаггүй. Төлбөр төлөгч Г.Алтан нь 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр нас барсан байх тул төлбөр төлөгч Г.Алтангийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийг 2013 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 156/01 дүгээр тогтоолоор битүүмжлэн шүүхийн шийдвэр сайн дураар биелүүлэх хугацаатай мэдэгдэл өгч тэмдэглэл хөтөлсөн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3 дахь хэсэгт заасны дагуу төлбөр авагчид үүргийн гүйцэтгэлд барьцаалагдсан эд хөрөнгийг шилжүүлэн өгөхөөр Ашигт малтмал, газрын тосны газарт хандан гаргасан хүсэлтийг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасан нь хууль зүйн үндэслэлгүй байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хуулийн дагуу явагдсан тул нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү гэжээ.

3. Анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн агуулга:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1-т зааснаар нэхэмжлэгч "Зөв зүг" ХХК-ийн хариуцагч Банкны төлбөр барагдуулах газарт холбогдуулан гаргасан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгуулах, тусгай зөвшөөрлийг битүүмжлэлээс чөлөөлөхийг даалгах тухай нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож,

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 60 дугаар зүйлийн 60.1, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь хэсэгт зааснаар нэхэмжлэгчийн улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 140,400 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

4. Нэхэмжлэгч талын давж заалдах гомдол, тайлбарын агуулга:

4.1. Тусгай зөвшөөрлийг битүүмжлэлээс чөлөөлүүлэх шаардлагын тухайд.

а. Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн 2013 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 1711 дүгээр захирамжийн дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 1/24181, 2015 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 1/26117 дугаартай албан бичгүүдээр MV-017172 дугаар

ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөнд тавьсан бүх хоригийг цуцалсан. Ашигт малтмалын газрын 2015 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 6/6923, 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 6/7116 дугаартай албан бичгүүдээр MV-017172 дугаар ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг "Зөв зүг" ХХК-д шилжүүлсэн болохыг мэдэгдсэн. "Зөв зүг" ХХК-д тусгай зөвшөөрөл нь барьцаанд байгаа талаар мөн "Олон овоот гоулд" ХХК-ийн үүргийн гүйцэтгэлд тооцон Хадгаламж банкинд шилжүүлэх гэж байгаа талаар аль ч байгууллага мэдэгдээгүй. "Зөв зүг" ХХК тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөр төлсөн баримтыг бүртгүүлж явахдаа 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр олж мэдээд Банкны төлбөр барагдуулах газарт гомдол гаргасан. "Зөв зүг" ХХК-ийн MV-019336 дугаар тусгай зөвшөөрөл нь барьцаанд байгаа эсэх талаар дэлгэрэнгүй лавлагааг Ашигт малтмал, газрын тосны газраас хүссэн боловч ямар ч хариу өгөөгүй. "Олон овоот гоулд" ХХК-ийн холбогдолтой аль ч шүүхийн шийдвэрт "Зөв зүг" ХХК үүрэг хүлээсэн, MV-017172 /одоогийн MV-019336/ дугаар ашиглалтын тусгай зөвшөөрлөөр үүргийн гүйцэтгэл хангуулахаар шийдвэрлээгүй. "Зөв зүг" ХХК нь Хадгаламж, Зоос, Анод банкуудаас зээл аваагүй, эдгээр банкуудтай зээл болон барьцааны гэрээ хийгээгүй, тусгай зөвшөөрлийг өөр этгээдэд шилжүүлэх хүсэлт гаргаагүй, хамааралгүй байсаар байхад шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага үүнийг нягталж шалгаж тогтоолгүй зөвхөн "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагч М.Энхтөрийн хүсэлтийг үндэслэн бусдын хөрөнгийг шилжүүлэхээр даалгасан. Иргэний хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1, 93 дугаар зүйлийн 93.1, 94 дүгээр зүйлийн 94.6, 159 дүгээр зүйлийн 159.5 дахь хэсэгт тус тус заасны дагуу "Зөв зүг" ХХК нь өөрийн эрхийг хамгаалах, хамгаалуулах эрхтэй.

б. "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагч 2015 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 655 дугаартай албан бичгээр Ашигт малтмалын газарт хариу хүргүүлэхдээ: "...дурдсан нэхэмжлэлийн шаардлагад Хадгаламж банкны барьцаанд бүртгэлтэй "Олон овоот гоулд" ХХК-ийн эзэмшлийн MV-017172 /XV-015281-ээс үүсмэл/ дугаар ашиглалтын тусгай зөвшөөрлөөр зээлийн гэрээний үүргийг хангуулах шаардлага багтсан" гэж дурдсан ба 2014 онд шүүхэд нэхэмжлэл гаргахдаа 017172А /одоогийн MV-019336/ дугаар ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг "үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцаалагч шаардах эрхтэй" гэж тодорхойлж үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар нэхэмжлэлийн шаардлагадаа дурдсан байсныг шүүхийн шийдвэр, магадлалд хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Ашигт малтмалын тухай хуульд зааснаар хайгуулын ажлыг гүйцэтгэсэн, зардал гаргаж ашигт малтмалын нөөцийг илрүүлсэн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн нөөцийг олборлох ашиглалтын тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргах эрхтэй, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасны үндсэн дээр хайгуулын талбайн аль ч хэсэгт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг онцгой эрхийнхээ дагуу авах эрхтэй байна.

в. 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагч М.Энхтөр MV-019336 тусгай зөвшөөрөл нь Хадгаламж банкны барьцаанд бүртгэлтэй байгаа гэх үндэслэлээр Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн 2013 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 1711 дүгээр захирамжийг хүчингүй болгуулахаар хүсэлт гаргасныг 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр шүүгч хянаад "... ашигт малтмалын MV-017172 дугаар тусгай зөвшөөрөл нь хүсэлтэд дурдсанчлан 2009 оны 012, 033 дугаартай зээлийн гэрээний үүргийн биелэлтийг хангах барьцаа хөрөнгө эсэх нь илэрхийлэгдэхгүй байна" гэж дүгнэн хүсэлтийг хангахгүй орхисон.

г. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2013 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 0390 дугаар шийдвэрээр "Олон овоот гоулд" ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, Ашигт малтмалын газрын нөөцөд бүртгэхгүй байгаа эс үйлдэхүйг хууль бусд тооцож, XV-015276, XV-015284, XV-016777 дугаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн талбайд тогтоогдож, Эрдэс баялгийн мэргэжлийн

зөвлөлийн дүгнэлтээр баталгаажсан нөөцийг ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх тухай шийдвэр гаргахыг Ашигт малтмалын газарт даалгаж шийдвэрлэсэн.

д. Иргэний хуулийн 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэгт "Барьцааны гэрээг бичгээр байгуулна", 156.2 дахь хэсэгт "Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг, улсын бүртгэлд бүртгүүлэх бөгөөд гэрээнд талуудын нэр, оршин суугаа /оршин байгаа/ газар, барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, үүргийг хангах хугацаа, барьцааны зүйл, түүний байгаа газар, үнийг заана" гэж заасан байх бөгөөд хэрэв хангаагүй бол мөн хуулийн 156 дугаар зүйлийн 156.3 дахь хэсэгт "Энэ хуулийн 156.1, 156.2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна" гэж заасан байгаа нь шүүгчийн дүгнэсэн шиг Х /хайгуулын/ тусгай зөвшөөрлөөс шинээр үүссэн А /ашиглалтын/ тусгай зөвшөөрлийн барьцааны гэрээ үргэлжлүүлэн хүчинтэй байна гэсэн хуулийн зохицуулалт байхгүй байна.

4.2. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийн тухайд.

а. Шүүхээс төлбөр гаргуулах тухай шүүхийн шийдвэрүүдэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.6-д заасны дагуу шийдвэрийг биелүүлэх арга журмаа тодорхойлсон байх бөгөөд тусгай зөвшөөрлүүдийг худалдан борлуулж түүнээс төлбөрийг барагдуулахыг даалгасан байдаг. Гэтэл шийдвэр гүйцэтгэгч худалдан борлуулах ажиллагаа явуулалгүйгээр шууд төлбөр авагчид шилжүүлсэн нь өөрөө хүний эд хөрөнгийг дээрэмдэж авсантай ялгаагүй үйлдэл болсон.

б. Ашигт малтмал, газрын тосны газрын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 1/5462 дугаартай хариуг үндэслэн "Зөв зүг" ХХК-ийн тусгай зөвшөөрлийг шилжүүлэхийг даалгасан гэж Банкны төлбөр барагдуулах газрын албан хаагч шүүх дээр хэлсэн байдаг. Гэтэл тус албан бичигт "Харин албан тоотод дурдсан ашиглалтын MV-019336 дугаар тусгай зөвшөөрөл "Зөв зүг" ХХК-ийн эзэмшилд байна", "2. Зөв зүг ХХК-ийн эзэмшилд ашигт малтмалын MV-019336 /MR-017172/ тоот тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр бөгөөд Хадгаламж банкны зээлийн барьцаанд бүртгэлтэй байна" гэж бичсэн хэдий ч ямар зээлийн болон барьцааны гэрээний үүргийн гүйцэтгэлд барьцаалагдсан байгаа талаар тодорхойлж дурдаагүй байхад Банкны төлбөр барагдуулах газар үүнийг "Олон овоот гоулд" ХХК-ийн өр төлбөрийн барьцаанд байна гэж дур мэдэн дүгнэлт хийж шилжүүлсэн нь ашиг сонирхол орсон илт дээрмийн шинж чанартай байна. "Зөв зүг" ХХК "Олон овоот гоулд" ХХК-ийн өмнөөс өр төлбөр төлөх үүрэг хүлээгээгүй. Мөн "... Татварын ерөнхий газрын том татвар төлөгчийн газрын тодорхойлолтыг зайлшгүй хавсаргана", "Иймд тусгай зөвшөөрлүүдийг шилжүүлэх өргөдөлд Ашигт малтмалын тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасан бичиг баримтуудыг бүрэн хавсарган ирүүлсэн тохиолдолд хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх боломжтойг үүгээр мэдэгдэж байна" гэсэн нь нэгдүгээрт, хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрүүд байсаар байтал "Шүүх болон шүүхийн шийдвэр манайд хамааралгүй бид өөрийн хуулиа л барьж шилжүүлнэ" гэсэн төрийн байгууллагуудын эрх мэдлийн хязгаараа мэдэхээ байсан, хуулийг өөртөө ашигтайгаар тайлбарлах зүйл байж болдог гэдгийн тод жишээ энэ хэрэгт илэрхий харагдаж байна. Хоёрдугаарт, Татварын хууль болон Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 302 дугаар тушаалын дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрөл татвар төлснөөр шилжих зохицуулалттай. Гэтэл "Олон овоот гоулд" ХХК-ийн өмнөөс Том татвар төлөгчийн газрын албан хаагч хуурамч бичилт хийж татвар төлсөн мэт болгон татварын тодорхойлолтыг Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлсэн нь илчлэгдэн хууль хяналтын байгууллагаар шалгагдаж байгааг дурдах нь зүйтэй. Үүнээс дүгнэхэд "Олон овоот гоулд" ХХК-ийн бүх тусгай зөвшөөрлүүдийг мөн "Зөв зүг" ХХК-ийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагч М.Энхтөрийн өмчлөлийн компанид шилжүүлж өгөхдөө тусгай зөвшөөрөл бүрийн үнэ цэнийг тогтоогоогүй, "Олон овоот гоулд" ХХК болон "Зөв зүг" ХХК өөрийн тусгай зөвшөөрлөө шилжүүлэх хүсэлт гаргаагүй байхад хүчээр мөн татваргүй шилжүүлсэн нь ноцтой асуудал болсон. Иргэний хуулийн 159 дүгээр зүйлийн 159.1 дэх

хэсэгт "Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцааны зүйлийг энэ хуульд заасан журмын дагуу дуудлага худалдаагаар худалдана", 159.2 дахь хэсэгт "Барьцаалуулагч шаардсан бол барьцааны зүйлийг худалдахын өмнө түүний үнэлгээг шинжээчээр тогтоолгож болох бөгөөд холбогдох зардлыг барьцаалуулагч хариуцна" гэж заасан байгаа нь хөрөнгийн үнэлгээг тогтоох шаардлагыг хуульчилсан. Гэтэл тусгай зөвшөөрлүүдийг тус бүр нь хэдэн төгрөгт тооцон төлбөр авагчид шилжүүлсэн эсэх нь тодорхой бус байгаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.2 дахь хэсэгт "Дуудлага худалдааг Иргэний хууль, энэ хуульд заасан журмын дагуу явуулна", 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт "Төлбөр төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас, эдийн бус хөрөнгө, түүх, соёлын өвд хамаарах үнэт зүйл, тусгай зөвшөөрлийг энэ хуульд заасны дагуу хөрөнгийн албадан дуудлага худалдаа /цаашид "дуудлага худалдаа" гэх/-аар худалдан борлуулна" гэж заасан байхад шүүгч хуулийн 63 дугаар зүйлийн 63.3 дахь хэсгийг дурдаж хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн байна. Энэ заалт нь худалдан борлуулахад тусгай зөвшөөрөл шаардагддаг галт зэвсэг, химийн хорт бодис, тэсэрч дэлбэрэх бодистой холбогдсон заалт буюу шийдвэр гүйцэтгэх байгууллагад тийм эрх байдаггүй бөгөөд тэдгээрийг худалдан борлуулахдаа тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд худалдуулахаар шилжүүлэх үйл ажиллагааг зохицуулсан заалтыг буруу ойлгож хэрэглэсэн. Дээрх хуулийн зохицуулалтаас харахад эхлээд барьцаа хөрөнгийн үнийг тогтоож дараа нь худалдан борлуулахаар байна.

в. Мөн шүүгч үндэслэх хэсгийн 11-т шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Ашигт малтмалын тухай хуулийн 52, 49 дүгээр зүйлд нийцсэн, энэ хууль нь илүү нарийвчлан зохицуулсан хууль тул хуульд нийцжээ гэж дүгнэсэн. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны үргэлжлэл гэж тодорхойлогддог энэ ч утгаараа Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт "Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ" гэж заасны дагуу Иргэний хуулийг баримтлах байсаар байхад хуулийг бас л буруу тайлбарлаж хэрэглэсэн гэж үзэхээр байна. Үнэхээр би буруу ойлгоод Ашигт малтмалын тухай хуулийг барих байлаа гэж үзэхэд Ашигт малтмалын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.10 дахь хэсэгт "Тусгай зөвшөөрөлтэй холбогдсон маргаан шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа бол шүүхийн шийдвэр гарах хүртэл тухайн тусгай зөвшөөрлийг шилжүүлэхийг хориглоно" гэж заасан байхад тусгай зөвшөөрлийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шилжүүлсэн үйл баримт байсаар байхад нэг талыг хэтэрхий барьж асуудлыг дүгнэлгүй шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зөв гэж дүгнэсэн нь өөрөө хэтэрхий алдаатай шийдвэр болсон гэж үзэхээр байна.

4.3. Барьцааны гэрээгээр илэрхийлэгдэх хэдэн төгрөгийн зээл авсан тухайд.

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2016 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 001/ХТ2016/00853 дугаар тогтоолоор "Олон овоот гоулд" ХХК-аас 45,491,354,932 төгрөг гаргуулж "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагчид олгохоор шийдвэрлэхдээ "...бусад банкнаас авсан зээлтэй холбоотойгоор хэд хэдэн банкны хооронд дундын барьцааны гэрээ байгуулагдсан энэ журмаар үүргээ хангуулна гэж нэхэмжлэгчийн зүгээс тайлбар гаргасан тул энэ талаар шийдвэр, магадлалд дурдах нь зүйтэй" гэж дүгнэсэн бөгөөд барьцааны зүйлээс үүргийг хангуулах эрхтэйг дурдсан байдаг. Тус тогтоолын 12 дахь хуудаст "Хэрэгт цугларсан баримтаас үзвэл "Олон овоот гоулд" ХХК нь 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 033-003 тоот зээлийн гэрээний дагуу авсан 10,194,255,000 төгрөг, 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 012/005 тоот зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах гэрээгээр авсан 18,610,605 ам.доллар, 2010 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн гэрээгээр авсан 2,200,000,000 төгрөг бүгд 45,491,354,932 төгрөгийг төлөх үүрэгтэй гэж үзнэ" гэжээ. Мөн тогтоолд дурдсан 2010 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн ООГ/155 дугаар барьцааны гэрээний Нэгд Хадгаламж банктai холбоотой

үүрэг "29, 11, 19, 28, 18, 27, 23, 57, 33, 12 тоот гэрээгээр хүлээсэн үүрэг 20,962,187,880 төгрөгийн мөнгөн төлбөр үүргийн биелэлтийг хангахтай холбогдуулан энэ гэрээний 2.1-т заасан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх (цаашид "Барьцааны зүйл" гэх)-ийг барьцаалах..." гэж гэрээ болон хүлээх үүргийн үнийн дүнг тодорхой дурдсан байна. Эдгээрээс дүгнэхэд Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолоор 45,491,354,932 төгрөг төлөхөөр гарснаас барьцааны гэрээний дагуу хүлээсэн үүрэг 20,962,187,880 төгрөгийн гэрээнүүдээс зөвхөн 2010 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн гэрээгээр авсан 2,200,000,000 төгрөгийг зээл авсан байна гэж дүгнэсэн нь барьцааны гэрээнд хамааралтай ба бусад зээлүүдийг аваагүй гэж дүгнэсэн.

4.4. "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагчийн Анод, Зоос банкуудаас авсан итгэмжлэлээр тэдгээрийн өмнөөс хөрөнгө захиран зарцуулсан үйлдэл нь хүчин төгөлдөр бус тухайд.

Анод болон Зоос банкнаас "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагч М.Энхтөрд олгосон итгэмжлэлд "Төлбөр төлөгч "Олон овоот гоулд" ХХК болон түүний хамаарал бүхий хуулийн этгээд, иргэнтэй харилцах, тэдгээрээс төлбөр төлөхийг шаардах, нэхэмжлэх; төрийн байгууллагуудад хандах, тэдгээртэй харилцах, шаардах эрхийг хэрэгжүүлэхийн тулд эрх зүйн харилцаанд төлөөлөх эрхтэй" гэжээ. Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2.1, 64.2.2, 64.3 дахь хэсэгт зааснаар хуулийн 64.2-т заасан шаардлагыг хангаагүй итгэмжлэл хүчин төгөлдөр бус байна. Иймд "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагч М.Энхтөр нь өөрийн хамаарал бүхий "Минерал эксплорейшн фандинг" ХХК дээр Анод, Зоос банкны өр төлбөрийг шилжүүлж авах хүсэлт гаргах эрхгүй этгээд байсаар байтал Банкны төлбөр барагдуулах газар түүний хүсэлтийг шийдвэрлэсэн.

4.5. Хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд.

"Зөв зүг" ХХК-аас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасны дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь түдгэлзүүлэх хүсэлт гаргасны дагуу шүүгчийн 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 181/ШЗ2023/21266 дугаар захирамжаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн. Гэтэл хэргийн оролцогч биш этгээд болох "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагч М.Энхтөрийн 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн хүсэлтийг үндэслэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1 дэх заалтыг үндэслэн 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 181/ШЗ2024/01310 дугаар захирамжаар шүүгчийн 181/ШЗ2023/21266 дугаар захирамжийг хүчингүй болгосон. Бид удаа дараа хүсэлт тавьсан боловч шалтаг шалтгаан тоочсоор шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлээгүй байтал 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдөр Банкны төлбөр барагдуулах газраас явуулсан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүнд 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдөр Ашигт малтмал, газрын тосны газар маргаан бүхий ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг гуравдагч этгээдэд шилжүүлсэн. Шүүх хуралдаан 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдөр хуралдсан бөгөөд шүүгч А.Цэлмэг өөрийн буруутай үйл ажиллагаагаа хамгаалах зорилгоор нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн. Иймд анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хангаж өгнө үү гэжээ.

5. Хариуцагч тал давж заалдах гомдолд тайлбар гаргаагүй болно.

ХЯНАВАЛ:

1. Давж заалдах шатны шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт зааснаар нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нарын гаргасан давж заалдах гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянаад, анхан шатны шүүхийн зарим дүгнэлтийг залруулж, шийдвэрт найруулгын өөрчлөлт оруулж, гомдлыг хангахгүй орхив.

2. Нэхэмжлэгч "Зөв зүг" ХХК нь хариуцагч Банкны төлбөр барагдуулах газарт холбогдуулан 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 1/4071 дугаартай албан бичгээр MV-019336 дугаар ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3 дахь хэсэгт заасны дагуу шилжүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газарт даалгасан ажиллагааг хүчингүй болгуулах, тусгай зөвшөөрлийг битүүмжлэлээс чөлөөлөхийг даалгах тухай нэхэмжлэл гаргасныг хариуцагч эс зөвшөөрч, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу явуулсан гэж маргажээ.

3. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 101/ШШ2016/01139 дугаар шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 689 дүгээр магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2016 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 001/ХТ2016/00853 дугаар тогтоолоор "Олон овоот гоулд" ХХК-аас 45,491,354,932 төгрөг гаргуулж, "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагчид олгож, барьцааны зүйлээс үүргийг хангуулах эрхтэйг дурдаж шийдвэрлэжээ. (2хх 94-142 дахь тал)

Уг шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр олгогдсон 2016 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 254 дугаартай гүйцэтгэх хуудсыг үндэслэн Банкны төлбөр барагдуулах газар нь албадан гүйцэтгэх ажиллагааг явуулжээ. (1хх 124 дэх тал)

4. Анхан шатны шүүх MV-019336 дугаар ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл баримтыг бүрэн дүгнээгүйг давж заалдах шатны шүүхээс нэмж дүгнэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

4.1. Шүүхийн шийдвэрт заасан 45,491,354,932 төгрөг нь "Олон овоот гоулд" ХХК, "Хадгаламж банк" ХХК-ийн хооронд байгуулагдсан 2009 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 012 тоот, 2009 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 033 тоот зээлийн гэрээнүүд, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулсан 2010 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 012/003, 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 012/005, 033-003 тоот гэрээнүүдийн нийт үүрэг болохыг шүүх дүгнэсэн.

Талууд зээлийн гэрээний үүргийг хангуулахаар 2009 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 012/033 тоот барьцааны гэрээ, 2010 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 012/033-01 тоот барьцааны нэмэлт гэрээгээр 15281Х дугаар ашигт малтмал хайгуулын тусгай зөвшөөрлийг барьцаалсан, уг тусгай зөвшөөрлөөс хэсэгчлэн шинээр авсан ашигт малтмалын MV-017172 дугаар ашиглалтын тусгай зөвшөөрлөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шаардлага гаргасан болох нь шүүхийн шийдвэрт бичигдсэн нэхэмжлэгч "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагчийн нэхэмжлэлийн талаарх тайлбарт тусгагджээ.

4.2. "Олон овоот гоулд" ХХК-д 15281Х дугаар ашигт малтмал хайгуулын тусгай зөвшөөрлийн 1773.74 га талбайд 2012 оны 10 дугаар сарын 15-ны өдөр MV-017172 дугаар ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон байна. (2хх 58-60 дахь тал)

4.3. Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн 2013 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 1711 дүгээр захирамжаар хариуцагч "Олон овоот гоулд" ХХК нь өөрийн эзэмшлийн MV-017172 дугаар ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг нэхэмжлэгч Э.Сүрэнгийн эзэмшилд шилжүүлснээр нэхэмжлэгчийн нэхэмжилсэн 11,505,619.34 ам.долларыг төлж барагдуулсанд тооцохоор зохигч эвлэрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. (1хх 6-7 дахь тал)

а. Тус шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны явцад Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн даргын 2015 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 710 дугаар шийдвэрээр "Олон овоот гоулд" ХХК-аас MV-017172 дугаар ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг "Зөв зүг" ХХК-д шилжүүлж бүртгэжээ. Мөн Кадастрын хэлтсийн даргын 2015 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 779 дүгээр шийдвэрээр "Зөв зүг" ХХК MV-017172 дугаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтыг гээгдүүлсэн тухай хүсэлт ирүүлснийг үндэслэн уг тусгай зөвшөөрлийг хүчингүйд тооцож, MV-019336 дугаар ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл нөхөн олгосон байна. (2хх 137-138 дахь тал)

б. Дээрх ажиллагааны хүрээнд Ашигт малтмалын газар нь 2015 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 6/6229 дугаартай албан бичгийг "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагчид хүргүүлж, "Олон овоот гоулд" ХХК-ийн эзэмшлийн MV-017172 /XV-015281-ээс үүсмэл/ дугаар ашиглалтын тусгай зөвшөөрлийг ШШГЕГ-ын НШГА-ны 2015 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 1/26117 тоот, 2013 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 1711 тоот шүүгчийн захирамжийн дагуу иргэн Э.Сүрэн /Зөв зүг ХХК/-д шилжүүлэх шийдвэр гарсны дагуу тусгай зөвшөөрлийг шилжүүлэх өргөдлийг хүлээн авч, хянаж байгаа талаар мэдэгдэж, ГУУКХ-ийн даргын 2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 1010 дугаар шийдвэрээр Хадгаламж банкинд барьцаалсныг бүртгэсэн уг тусгай зөвшөөрлийг шилжүүлэхтэй холбоотой саналаа ирүүлэхийг мэдэгджээ. (2хх 51 дэх тал)

в. Уг албан бичгийн хариуд "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагчаас 2015 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 655 дугаартай албан бичгээр "Олон овоот гоулд" ХХК-аас нийт 68.2 тэрбум төгрөг гаргуулж, үүргийн гүйцэтгэлийг ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүд болон бусад барьцаа хөрөнгөөр хангуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг шүүхэд гаргасан, нэхэмжлэлийн шаардлагад түүний барьцаанд бүртгэлтэй "Олон овоот гоулд" ХХК-ийн эзэмшлийн MV-017172 /XV-015281-ээс үүсмэл/ дугаар ашиглалтын тусгай зөвшөөрлөөр эзэлийн гэрээний үүргийг хангуулах шаардлага багтсан, тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэх хууль зүйн үндэслэлгүй талаар мэдэгджээ. Өөрөөр хэлбэл "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагч нь барьцааны эрх бүхий тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг зөвшөөрөөгүй байна. (2хх 188-189 дэх тал)

г. Үүнээс гадна шийдвэр гүйцэтгэлийн хувийн хэрэгт авагдсан "Олон овоот гоулд" ХХК-ийн хувьцаа эзэмшигч Г.Алтангийн өв залгамжлалтай холбоотой баримтуудад дурдсанаар Э.Сүрэн нь Г.Алтангийн хүү буюу нэгдмэл сонирхолтой этгээд байх тул тэрээр "Олон овоот гоулд" ХХК-тай эвлэрлийн гэрээ байгуулахдаа MV-017172 дугаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөлд барьцаа бүртгэлтэйг мэдэх боломжтой, шүүгчийн захирамжид тусгагдсан түүний тайлбарт энэ агуулга илэрхийлэгдсэн байна.

д. Дээрх баримтуудыг харьцуулж дүгнэхэд, "Олон овоот гоулд" ХХК-аас MV-017172 дугаар ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл "Зөв зүг" ХХК-д шилжиж, барьцааны зүйлийн өмчлөгч өөрчлөгдсөн хэдий ч барьцааны эрх Иргэний хуулийн 153 дугаар зүйлийн 153.1 дэх хэсэгт зааснаар хүчинтэй хэвээр байна.

е. Нэхэмжлэгч нь "2009 онд хамаарах барьцааны гэрээ болох 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн ЗБГ/142 тоот барьцааны гэрээг шүүхийн шийдвэрээр хүчин төгөлдөр бусд тооцсон" гэж тайлбарласан нь дор дурдсанаар үндэслэлгүй.

- Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 2022/Ч дугаар шийдвэрээр Монгол шуудан банк, "Олон овоот гоулд" ХХК-ийн хооронд байгуулагдсан 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн ЗБГ/142 тоот барьцааны гэрээг хүчин төгөлдөр бусд тооцож, барьцааны эрх дуусгавар болсныг нотолсон баримтыг Ашигт малтмалын газарт хүргүүлэхийг "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагчид даалгаж шийдвэрлэжээ.

Шүүхийн шийдвэрээс үзэхэд, "Голомт банк" ХХК нь "Олон овоот гоулд" ХХК-ийн эзэмшлийн XV-15276 дугаар тусгай зөвшөөрлөөс 2011 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр

хэсэгчлэн олгосон MV-016759, XV-016777 дугаар тусгай зөвшөөрлүүдийг өөрийн өр төлбөрт тооцож шилжүүлэн авах зорилгоор тухайн нэхэмжлэлийг гаргасан байх ба эдгээр тусгай зөвшөөрөл нь талуудын маргаанд хамааралгүй байна.

- Мөн ЗБГ/142 тоот барьцааны гэрээнд тусгагдсан 7 тусгай зөвшөөрлийн нэг нь 15281Х дугаар тусгай зөвшөөрөл байх хэдий ч албадан биелүүлж буй Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 101/ШШ2016/01139 дугаар шийдвэрт өөр барьцааны гэрээ буюу 2009 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 012/033 тоот барьцааны гэрээ, 2010 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 012/033-01 тоот барьцааны нэмэлт гэрээ хамаарахыг дурдах нь зүйтэй. (2хх 197-204 дэх тал)

4.4. "Олон овоот гоулд" ХХК болон нэр бүхий банкуудын байгуулсан 2010 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн ООГ/155 тоот барьцааны гэрээний хавсралт №1-д тусгагдсан "Олон овоот гоулд" ХХК болон бусад этгээдийн 44 тусгай зөвшөөрлийн жагсаалтад 15281Х дугаар тусгай зөвшөөрөл бичигдсэн боловч MV-017172, XV-015281 дугаар тусгай зөвшөөрлүүд дангаараа "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагчийн барьцаанд, харин "Олон овоот гоулд" ХХК-ийн өөр 11 тусгай зөвшөөрөл банкуудын дундын барьцаанд бүртгэгдсэн болох нь хэрэгт авагдсан Ашигт малтмалын газрын 2013 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 6-5034 дугаартай албан бичгээр тогтоогджээ. (2хх 181 дэх тал)

5. Банкны өр барагдуулах газарт MV-019336 дугаар ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл нь "Зөв зүг" ХХК-ийн эзэмшилд бүртгэлтэй, хүчин төгөлдөр бөгөөд Хадгаламж банкны зээлийн барьцаанд бүртгэлтэй талаар Ашигт малтмал, газрын тосны газрын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 1/5462 дугаартай албан бичгээр мэдэгджээ. (2хх 137-138 дахь тал)

Уг албан бичигт маргаан бүхий MV-019336 дугаар тусгай зөвшөөрлөөс гадна "Олон овоот гоулд" ХХК-ийн эзэмшлийн MV-015274, MV-015275, MV-015282, MV-015283, MV-020764, MV-021489, MV-021490 дугаар ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлүүд Голомт, Хадгаламж, Зоос, Анод банкны барьцаанд бүртгэлтэй талаар тусгасан байх бөгөөд хариуцагч нь хүчин төгөлдөр 18 шүүхийн шийдвэрээр "Олон овоот гоулд" ХХК-аас "Анод банк" ХК дахь Банкны эрх хүлээн авагч, "Зоос банк" ХК дахь Банкны эрх хүлээн авагч, "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагчид тус тус олгохоор шийдвэрлэсэн нийт 148,534,984,060 төгрөгийн өр төлбөрт Ашигт малтмалын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэгт заасан барьцааг хэрэгжүүлэх журмын дагуу эдгээр 8 тусгай зөвшөөрлийг "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагчийн охин компани болох "Монголын актив удирдлагын корпораци" ХХК, "Минерал эксплорэйшн фандинг" ХХК-д шилжүүлэхээр шийдвэрлэжээ.

6. Дээр дурдсаныг нэгтгэн дүгнэхэд, хариуцагч Банкны төлбөр барагдуулах газар нь Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 101/ШШ2016/01139 дугаар шийдвэр болон 2016 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 254 дугаартай гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн "Олон овоот гоулд" ХХК-аас гаргуулж "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагчид олгох 45,491,354,932 төгрөгийн үүргийг барьцаа хөрөнгө болох нэхэмжлэгч "Зөв зүг" ХХК-ийн эзэмшлийн MV-019336 дугаар ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлөөр хангуулахаар 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 1/4071 дугаартай албан бичгийг Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлсэн нь үндэслэлтэй. Тодруулбал, уг тусгай зөвшөөрлийг төлбөр авагч "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагчийн охин компани болох "Монголын актив удирдлагын корпораци" ХХК, "Минерал эксплорэйшн фандинг" ХХК-д шилжүүлэхийг даалгасан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44

дүгээр зүйлийн 44.2.18, Иргэний хуулийн 153 дугаар зүйлийн 153.1, Ашигт малтмалын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.2 дахь хэсэгт заасныг зөрчөөгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар эрх бүхий захиргааны байгууллагын эрхэлдэг тусгай зөвшөөрлийн барьцааны бүртгэл үнэн зөв эсэхийг тогтоохгүй тул “Зөв зүг” ХХК нь MV-019336 дугаар тусгай зөвшөөрөлд барьцааны гэрээ хийгээгүй, барьцаагаар шаардагдах үүргийн гүйцэтгэлийг шилжүүлэн аваагүй” гэх нэхэмжлэгчийн гомдлыг хүлээн авах боломжгүй. Мөн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн барьцааг хэрэгжүүлэх журмыг Ашигт малтмалын тухай хуулийн 52 дугаар зүйлд тусгайлан тогтоосон тул “тусгай зөвшөөрлийг албадан худалдан борлуулаагүй” гэх гомдол мөн хангагдахгүй.

Иймд хариуцагчид холбогдуулан гаргасан 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 1/4071 дугаартай албан бичгээр MV-019336 дугаар ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газарт даалгасан ажиллагааг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг анхан шатны шүүх хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэгт заасантай нийцсэн.

7. Нэхэмжлэгч нь “MV-019336 дугаар ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг битүүмжлэлээс чөлөөлөхийг даалгах” шаардлагын үндэслэлээ хариуцагчийн 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 1/4071 дугаартай албан бичигт үндэслэн тайлбарлажээ.

Уг албан бичигт тусгай зөвшөөрлийг төлбөр авагчийн заасан этгээдэд шилжүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газарт мэдэгдэхдээ хариуцагч байгууллагын 2016 оны 3/1569, 2017 оны 3/141, 2018 оны 3/7350, 2020 оны 3/2565 дугаартай албан бичгүүдээр өмнө нь эрх түдгэлзүүлснийг сэргээхээр заасан байна.

Ашигт малтмал, газрын тосны газрын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 1/5462 дугаартай албан бичгээс үзэхэд, “Зөв зүг” ХХК-ийн эзэмшлийн MV-019336 дугаар ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөн хийх эрхийг 2016 оны 3/1569 дугаартай албан бичгээр түдгэлзүүлснийг дээрх 1/4071 дугаартай албан бичгийн дагуу чөлөөлөх бүртгэл хийгджээ. Харин 2017 оны 3/141, 2018 оны 3/7350, 2020 оны 3/2565 дугаартай албан бичгүүд нь уг тусгай зөвшөөрөлд хамааралгүй байна. (1хх 137-139 дэх тал)

Иймээс Ашигт малтмал, газрын тосны газарт MV-019336 дугаар тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөн хийх эрхийг түдгэлзүүлснийг сэргээсэн байх тул энэ талаарх нэхэмжлэлийн шаардлагыг шүүх хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь зөв.

8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн түдгэлзүүлэх эсэх нь шүүгчийн эрх хэмжээнд хамаарах тул энэ талаар гаргасан нэхэмжлэгчийн гомдлыг хүлээн авах үндэслэлгүй.

9. Анхан шатны шүүх хариуцагчид холбогдуулан гаргасан нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэгт заасантай нийцсэн тул нэхэмжлэгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхих нь зүйтэй. Харин шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтад нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн тусгаагүй нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсэгт нийцээгүйг залруулж найруулгын өөрчлөлт оруулахаар шүүх бүрэлдэхүүн тогтов.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 167 дугаар зүйлийн 167.1.2-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 181/ШШ2024/02980 дугаар шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтыг "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэгт заасныг баримтлан хариуцагч Банкны төлбөр барагдуулах газарт холбогдуулан гаргасан 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 1/4071 дугаартай албан бичгээр MV-019336 дугаар ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3 дахь хэсэгт заасны дагуу шилжүүлэхийг Ашигт малтмал, газрын тосны газарт даалгасан ажиллагааг хүчингүй болгуулах, тусгай зөвшөөрлийг битүүмжлэлээс чөлөөлөхийг даалгах тухай нэхэмжлэгч "Зөв зүг" ХХК-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай" гэж өөрчилж, шийдвэрийн бусад хэсгийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нарын давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 162 дугаар зүйлийн 162.4 дэх хэсэгт зааснаар давж заалдах гомдол гаргахдаа улсын тэмдэгтийн хураамжид нэхэмжлэгчийн төлсөн 70,200 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 167 дугаар зүйлийн 167.3, 172 дугаар зүйлийн 172.1 дэх хэсэгт зааснаар магадлал танилцуулан сонсгомогц хүчинтэй болох бөгөөд зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч магадлалыг эс зөвшөөрвөл гардан авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор хяналтын журмаар Улсын Дээд шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.


4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.4, 119.7 дахь хэсэгт тус тус зааснаар магадлалыг танилцуулан сонсгож, 14 хоног өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор шүүхэд хүрэлцэн ирж магадлалыг гардан авах үүргээ биелүүлээгүй нь хяналтын журмаар гомдол гаргах хугацааг тоолоход саад болохгүй бөгөөд шүүх хуралдаанд оролцоогүй талд гардуулснаар гомдол гаргах хугацааг тоолохыг тайлбарласугай.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ

Ч.ЦЭНД

ШҮҮГЧИД ДЭЛГЭРЦЭЦЭГ

Д.ЗОЛЗАЯА





МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ХЯНАЛТЫН ШАТНЫ ИРГЭНИЙ ХЭРГИЙН
ШҮҮХ ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2016 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 001/ХТ2016/00853

Улаанбаатар хот

Хадгаламж банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчийн
нэхэмжлэлтэй иргэний хэргийн тухай

Монгол Улсын Дээд шүүхийн Танхимын тэргүүн Х.Сонинбаяр даргалж, шүүгч
Г.Алтанчимэг, П.Золзаяа, Г.Цагаанцоож, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй тус
шүүхийн танхимд хийсэн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар

Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн
2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 101/ШШ2016/01139 дүгээр шийдвэр,

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн
2016 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 689 дүгээр магадлалтай,

Хадгаламж банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчийн нэхэмжлэлтэй
"Олон овоот гоулд" ХХК-д холбогдох

Зээлийн гэрээний үүрэгт 68 213 832 500 төгрөг гаргуулах, үүргийн гүйцэтгэлийг
барьцаа хөрөнгөөр хангуулах, барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд санхүүгийн бусад
эх үүсвэрээс төлүүлэхээр шүүхийн шийдвэрт тусгуулах тухай нэхэмжлэлтэй иргэний
хэргийг

Нэхэмжлэгчийн төлөөлөгчийн гаргасан хяналтын гомдлоор
шүүгч П.Золзаяагийн илтгэснээр хянан хэлэлцэв.

Шүүх хуралдаанд: нэхэмжлэгчийн төлөөлөгч Ч.Аварзэд, нэхэмжлэгчийн өмгөөлөгч
Б.Даваажанцан, Д.Гантөмөр, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Баатаргэрэл,
хариуцагчийн өмгөөлөгч Л.Сарангэрэл, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга
И.Хажидмаа нар оролцов.

Нэхэмжлэгчийн төлөөлөгч шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ болон өмгөөлөгчийн
хамт шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: "Олон овоот гоулд" ХХК нь Хадгаламж
банкаас зээлийн гэрээг байгуулж 2009 оны 08 дугаар сарын 21-ний өдөр 012 дугаартай
зээлийн гэрээ байгуулж 1 750 000 000 төгрөгийг эргэлтийн хөрөнгийн санхүүжүүлтийн
зориулалтаар, 1 сарын 1,9 хувийн хүүтэй, 6 сарын хугацаагаар, 2009 оны 12 дугаар сарын
07-ны өдрийн 012-001 дугаартай зээлийн нэмэлт гэрээгээр 660 000 000 төгрөгийг, 2009
оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 033 дугаартай зээлийн гэрээ байгуулж 1 800 000
ам.долларыг эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн зориулалтаар, сарын 1,9 хувийн хүүтэй,
6 сарын хугацаагаар, 2010 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 047 дугаартай зээлийн
гэрээ байгуулж 2 876 355 554 төгрөгийг эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн
зориулалтаар, сарын 1,8 хувийн хүүтэй, 24 сарын хугацаагаар, 2012 оны 08 дугаар сарын
30-ны өдрийн 033/3 дугаартай зээлийн нэмэлт гэрээгээр 10 194 255 000 төгрөгийг, 2012
оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 012/005 дугаартай зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт
оруулах гэрээгээр 18 610 605 ам.долларыг тус тус зээлсэн. "Олон овоот гоулд" ХХК нь
2009 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 012-001 дугаартай зээлийн нэмэлт гэрээгээр

авсан 660 000 000 төгрөгийн зээлээс 210 000 000 төгрөгийн зээлийг 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдөр төлсөн, 2010 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр 224 919 99 төгрөг төлсөн, 2010 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 047 дугаартай зээлийн гэрээгээр авсан 2 876 355 554 төгрөгийн зээлээс 30 943 99 төгрөг төлсөн. Талууд харилцан тохиролцож зээлийн үлдэгдлийг бусад валютад хөрвүүлсэн. 2010 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 012/003 дугаартай зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээгээр 2009 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 012 тоот зээлийн гэрээгээр олгосон 1 750 000 000 төгрөгийн зээл дээр 2009 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 012-001 тоот зээлийн гэрээний нэмэлтээр олгосон 660 000 000 төгрөгийн зээлийн үлдэгдэл 449 775 080 төгрөгийг нэмж нийт үлдэгдэл 2 199 775 080 төгрөгийг 2010 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн Монголбанкны албан ханшаар 1 318.81 төгрөгөөр тооцон 1 668 000 ам.долларт хөрвүүлсэн. 2010 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 033-001 тоот зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээгээр 2009 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 033 тоот зээлийн гэрээгээр олгосон 1 800 000 ам.долларыг 2010 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн Монголбанкны ханш 1 385.98 төгрөгөөр тооцон 2 494 764 000 төгрөгт хөрвүүлсэн. 2010 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 47/001 дугаартай зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээгээр 2010 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 47 тоот зээлийн гэрээгээр олгосон 2 876 355 554 төгрөгийн зээлийн өр төлбөрөөс 30 943 99 төгрөгийн зээлийн төлөлтийг хасаж зээлийн үлдэгдэл болох 2 876 324 610 төгрөгийг 2010 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн Монголбанкны ханш 1318.81 төгрөгөөр тооцон 2 181 000 ам.долларт хөрвүүлсэн. "Олон овоот гоулд" ХХК нь 2011 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Хадгаламж банкттай 033/002 дугаартай зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг байгуулж дараах компаниудын зээлийн гэрээгээр хүлээсэн үүргийг батлан даалтын гэрээний дагуу нэгтгэн төлөхөөр харилцан тохиролцсон. "Си Ти Эр" ХХК-ийн Хадгаламж банкттай байгуулсан 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 3Г/015 тоот зээлийн гэрээний үлдэгдэл 888 600 000 төгрөг, "Эм Жи Эйч" ХХК-ийн Хадгаламж банкттай байгуулсан 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 3Г/013 тоот зээлийн гэрээний үлдэгдэл 3 748 100 391 төгрөг, "Эм Жи Эйч" ХХК-ийн Хадгаламж банкттай байгуулсан 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 3Г/014 тоот зээлийн гэрээний үлдэгдэл 690 281 100 төгрөг, "Эрдтана" ХХК-ийн 2010 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 48 тоот зээлийн гэрээ, 2010 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 48/001 тоот зээлийн нэмэлт өөрчлөлтүүдийн үлдэгдэл 4 334 000 000 төгрөгийг тус тус "Олон овоот гоулд" ХХК нь батлан даалтын гэрээний өр төлбөрийг Хадгаламж банкинд төлөх үүрэг хүлээсэн. "Баяраам" ХХК-ийн Хадгаламж банкттай 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан 3Г/016 тоот зээлийн гэрээний үлдэгдэл 3 245 394 ам.долларыг "Олон овоот гоулд" ХХК нь 2011 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Хадгаламж банкттай 012/004 дугаартай зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг байгуулж зээлийн гэрээгээр хүлээсэн үүргийг батлан даалтын гэрээний дагуу нэгтгэн төлөхөөр харилцан тохиролцсон. "Олон овоот гоулд" ХХК-ийн өөрийн авсан зээлийн үлдэгдэл болон бусдын зээлийн гэрээгээр Хадгаламж банкны өмнө хүлээсэн үүргийг нэгтгэж Хадгаламж банкинд төлөх нийт өр төлбөрийг нэгтгэсэн байдал, Хадгаламж банкинд ам.доллараар төлөх нийт өр төлбөрийг нэг мөр болгох зорилгоор Хадгаламж банк болон "Олон овоот гоулд" ХХК нь 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдөр №012-005 дугаартай зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг байгуулж, уг гэрээгээр ам.долларын зээлийн өр төлбөрийг нийт 25 705 000 ам.доллараар тогтоосонд дараах өр төлбөрүүд багтсан. 2012 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 012-003 тоот зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээгээр 2 199 775 080 төгрөгийг ам.долларт хөрвүүлсэн 1 668 000 ам.доллар, 2010 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 47/001 дугаартай зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээгээр 2 876 324 610 төгрөгийг ам.долларт хөрвүүлсэн 2 181 000 ам.доллар, "Баяраам" ХХК-ийн 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 3Г/016 тоот зээлийн гэрээний үлдэгдэл 3 245 394 ам.доллар, 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн №012-005 дугаартай зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээгээр нэмж авсан 18 610 605 ам.доллар, Хадгаламж банкинд төгрөгөөр төлөх нийт өр төлбөрийг нэг мөр болгох зорилгоор Хадгаламж банк болон "Олон овоот гоулд" ХХК нь 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдөр 033/003 дугаартай зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ байгуулсан. Тус гэрээгээр төгрөгийн зээлийн өр төлбөрийг нийт 22 500 000 000 төгрөгөөр тогтоосон ба үүнд дараах өр төлбөрүүд багтсан. 2010 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 033-001 тоот зээлийн нэмэлт гэрээгээр 1 800 000 ам.долларын зээлийг төгрөгийн зээлд

хөрвүүлсэн 2 494 764 000 төгрөг, "Си Ти Эр" ХХК-ийн Хадгаламж банктай байгуулсан 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн ЗГ/015 тоот зээлийн гэрээний үлдэгдэл болох 888 600 000 төгрөг, "Эм Жи Эйч" ХХК-ийн Хадгаламж банктай байгуулсан 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн ЗГ/013 тоот зээлийн гэрээний үлдэгдэл болох 3 748 100 391 төгрөг, "Эм Жи Эйч" ХХК-ийн Хадгаламж банктай байгуулсан 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн ЗГ/013 тоот зээлийн гэрээний үлдэгдэл 690 281 100 төгрөг, "Эрдтана" ХХК-ийн 2010 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 48 тоот зээлийн гэрээ, 2010 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 48/001 тоот зээлийн нэмэлт өөрчлөлтүүдийн үлдэгдэл 4 334 000 000 төгрөг, бусад зээл 150 000 000 төгрөг, 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 033/3 дугаартай зээлийн нэмэлт гэрээгээр 10 194 255 000 төгрөг болно. Гэрээний зөрчлийн талаар, 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн №012-005 дугаартай зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээний 25 705 000 ам.долларыг 2013 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн төлж барагдуулах үүрэг хүлээсэн ч нэг ч ам.долларын төлбөрийг хийгээгүй. 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн №033-003 тоот зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээгээр 10 000 000 000 төгрөгийг 2013 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор, 12 500 000 000 төгрөгийг 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор тус тус төлөх үүрэг хүлээсэн ч нэхэмжлэл гаргах өдрийн байдлаар огт төлөлт хийгдээгүй. Иймд нэхэмжлэгчийн зүгээс Хадгаламж банк, "Олон овоот гоулд" ХХК-аас хамгийн сүүлд өөрчлөн байгуулсан 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн №033-003 тоот зээлийн гэрээний дагуу зээлийн өр төлбөрт 22 500 000 000 төгрөг, 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн №012-005 дугаартай зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээний өр төлбөр 25 705 000 ам.долларыг нэхэмжлэл гаргах 2014 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн Монголбанкны зарласан албан ханш нэг ам.долларыг 1 778.40 төгрөгөөр тооцон 45 713 772 000 төгрөг, нотариатын хөлс 60 500 төгрөг, нийт 68 213 832 500 төгрөгийг нэхэмжлэх үндэслэлтэй. "Олон овоот гоулд" ХХК нь дээр дурдсан зээлүүдийн үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож дараах барьцааны гэрээг тус тус байгуулсан бөгөөд барьцааны гэрээнд тусгагдсан эд хөрөнгө, ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийг эрэл, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, техник, эдийн засгийн үндэслэл, холбогдох бичиг баримтын хамтаар барьцаалсан. Иргэний хуулийн 157 дугаар зүйлийн 157.1-д зааснаар барьцаалагч нь барьцаагаар хангагдах шаардлагын хэмжээнд барьцааны зүйлийн үр шимийг олж авах эрхийг эдэлдэг тул ашигт малтмалын хайгуулын 15276Х тусгай зөвшөөрлөөс хэсэгчлэн шилжүүлж шинээр авсан хайгуулын 16777Х зөвшөөрөл, ашиглалтын 16759А тоот хайгуулын тусгай зөвшөөрөл, 17172А тоот тусгай зөвшөөрлүүдээр үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцаалагч шаардах эрхтэй. Хадгаламж банк ХХК нь Анод банк ХХК, Зоос банк ХХК, Голомт банк ХХК нарын хамтаар ООГ/155 дугаартай гэрээний хавсралт №1-д заасан "Олон овоот гоулд" ХХК-ийн эзэмшлийн ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын дараах тусгай зөвшөөрлүүдийг тухайн газарт хийгдсэн эрэл, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, геологийн судалгааны мэдээлэл, техник, эдийн засгийн үндэслэлийн хамтаар, гэрээний хавсралт 2-т заасан барьцаалуулагчийн өмчлөлийн техник тоног төхөөрөмж, газар эзэмших эрхүүдийг барьцаалсан. Талуудын хооронд 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдөр байгуулагдсан 012/005 дугаартай зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээний дагуу хариуцагчаас зээлийн өр төлбөрт 25 705 000 ам.долларыг 2014 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн Монголбанкны зарласан албан ханш нэг ам.долларыг 1 778 40 төгрөгөөр тооцон 45 713 772 000 төгрөг, 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн №033-003 тоот зээлийн гэрээний дагуу зээлийн өр төлбөрт 22 500 000 000 төгрөгийг, нотариатын хөлс 60 500 төгрөгийн хамт нийт 68 213 832 500 төгрөг гаргуулах, зээлдэгч нь шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд 012/033, 012/033-001, ООГ/155 тоот барьцааны гэрээгээр барьцаалагдсан барьцааны гэрээний хавсралтад дурдсан ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүд, 37 нэр нэр төрлийн техник, тоног төхөөрөмжүүд, 9 ширхэг нэр бүхий газар эзэмших эрхүүдээр тус тус үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай Барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд хариуцагчийн бусад хөрөнгө, үл хөдлөх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, бусад санхүүгийн эх үүсвэрүүдээс өр төлбөрийг төлүүлэх талаар шүүхийн шийдвэрт тусгайлан зааж өгнө үү гэжээ.

Хариуцагчийн төлөөлөгч шүүхэд болон итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: 2009 оны 08 дугаар сарын 21-ний өдөр Хадгаламж банктай ЗГ-012 тоот зээлийн гэрээ хийж 1 750 000 000 төгрөгийн зээлийг сарын 1,9 хувийн

хүүтэй, 6 сарын хугацаатай зээлийн гэрээ хийсэн. Гэрээний дагуу "Олон овоот гоулд" ХХК-ийн Хадгаламж банкинд байрлах №1012000407 тоот дансанд 2009 оны 08 дугаар сарын 21-ний өдөр 450 000 000 төгрөг ороод 2009 оны 08 дугаар сарын 21-ний өдөр буцаад манай компанийн №1012000407 тоот данснаас банк хоорондын гүйлгээ гэж гарсан. Анхан шатны баримт болон санхүү программ байхгүй улмаас хаашаа гарсан, хүлээн авагч нь хэн болох мэдэгдэхгүй байна. №1012000407 тоот дансанд 2009 оны 08 дугаар сарын 25-ны өдөр 780 000 000 төгрөг ороод мөн өдрөө Л.Бадамцэцэг чекээр 780 000 000 төгрөг авсан. Дээрх гүйлгээнүүдийг тодруулахаар удаа дараа Хадгаламж банкны эрх хүлээн авагчид хандсан ч төлбөрийн даалгавар болон данснаас чекээр авсан чекийг өнөөдрийг хүртэл шүүхэд гаргаж өгөөгүй. Иймд дээрх зээлийг манай компани аваагүй бөгөөд тухайн үеийн Хадгаламж банкны удирдлагуудын хийсэн санхүүгийн луйвар гэж үзэж байна.

Манайх 2009 оны 10 дугаар сарын 09-ний өдөр Хадгаламж банкттай ЗГ-033 тоот зээлийн гэрээ хийж 1 800 000 ам.долларын зээлийг сарын 1,5 хувийн хүүтэй, 6 сарын хугацаатай зээлийн гэрээ хийсний дагуу манай компанийн Хадгаламж банкинд байрлах №1012000404 тоот ам.долларын дансанд 2009 оны 10 дугаар сарын 28-ны өдөр 1 000 000 ам.доллар ороод 2009 оны 10 дугаар сарын 28-ны өдөр уг данснаас 1 000 000 ам.доллар, мөн өдрөө 100 000 ам.доллар дахин валютын арилжаа хийсэн гэж буцаад гарсан. Мөн №1012000404 тоот данснаас 2009 оны 10 дугаар сарын 28-ны өдөр, 2009 оны 10 дугаар сарын 30-ны өдөр 400 000 ам.долларыг Л.Бадамцэцэг чекээр авсан. Уг гүйлгээнүүдийг хийхийг даалгасан компаниас банкинд өгсөн төлбөрийн даалгавар болон чек нь тус компанид байхгүй бөгөөд Хадгаламж банкны эрх хүлээн авагчид хандсан ч гаргаж өгөөгүй. Зээлийн гэрээ №033 тоот олгогдсон 1 000 000 ам.доллар гүйлгээ мөн 100 000 ам.доллар, 400 000 ам.долларын зарлагын гүйлгээг "Жаст групп" ХХК, Хадгаламж банкттай харилцан хамааралтай этгээд Л.Бадамцэцэг хийсэн. Иймд дээрх зээлээс 1 500 000 ам.долларыг манай компани аваагүй хуурамч гүйлгээ. "Олон овоот гоулд" ХХК нь 2010 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Хадгаламж банкттай ЗГ-47 тоот зээлийн гэрээ хийж 2 876 355 554 төгрөгийн зээлийг сарын 1,8 хувийн хүүтэй, 24 сарын хугацаатай зээлийн гэрээ хийсэн ч 2 876 355 554 төгрөг нь манай компанийн дансанд ороогүй. "Олон овоот гоулд" ХХК нь 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Хадгаламж банкттай ЗГ-033-003 тоот зээлийн гэрээ хийж 10 194 255 000 төгрөгийн зээлийг хүүгүй, 21 сарын хугацаатай зээлийн гэрээний дагуу "Олон овоот гоулд" ХХК-ийн Хадгаламж банкинд байрлах №1012000407 тоот төгрөгийн дансанд 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдөр 10 194 255 000 төгрөг ороод тэр өдрөө Хадгаламж банкны алтны ачилттай холбоотой үүсэн гэх төлбөрт 7 737 572 321 төгрөг, "Жи Эм Эс Си" ХХК-д 1 453 155 133 төгрөг, Монгол шуудан банк руу 1 000 000 000 төгрөг тус тус шилжсэн. Хадгаламж банкны алтны ачилттай холбоотой үүсэн 7 737 572 321 төгрөг яаж үүссэн талаар тооцоо байхгүй бөгөөд "Олон овоот гоулд" ХХК-д Хадгаламж банк нь хуурамч өглөг үүсгэсэн гэж үзсэн. Монгол шуудан банкинд тус компани нь өргүй. Дээрх гүйлгээнүүдийг хийхийг даалгасан компаниас банкинд өгсөн төлбөрийн даалгавар нь тус компанид байхгүй бөгөөд Хадгаламж банкны эрх хүлээн авагчид хандсан ч гаргаж өгөөгүй. Манайх 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Хадгаламж банкттай ЗГ-012-005 тоот зээлийн гэрээ хийж 18 610 605 ам.долларын зээлийг хүүгүй, 12 сарын хугацаатай зээлийн гэрээ хийсний дагуу манай №1012000404 тоот ам.долларын дансанд 18 610 605 ам.доллар орсон ч тэр өдрөө буцаад гарсан. №012-005 тоот гэрээний дагуу 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдөр "Олон овоот гоулд" ХХК-ийн Хадгаламж банкинд байрлах №1012000404 тоот долларын дансанд 18 610 605 ам.доллар орсон ч тэр өдрөө буцаад уг данснаас "Суробан" ХХК-ийн авлагыг төлөв гэх гүйлгээний утгатай гарсан байдаг. Энэ гүйлгээг "Суробан" ХХК-аас тодруулахад манай дансанд 18 610 605 ам.доллар ороогүй, танайхаас авлагагүй гэх баримт, тайлбарыг өгсөн. Эдгээр гүйлгээг хийхийг даалгасан компаниас банкинд өгсөн төлбөрийн даалгавар нь тус компанид байхгүй бөгөөд Хадгаламж банкны эрх хүлээн авагчид хандсан ч гаргаж өгөөгүй. "Олон овоот гоулд" ХХК нь 2011 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Хадгаламж банкттай 033-002 дугаартай зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг байгуулж дараах компаниудын зээлийн гэрээгээр хүлээсэн үүргийг батлан даалтын гэрээний дагуу нэгтгэн төлөхөөр харилцан тохиролцсон. "Си Ти Эр" ХХК 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдөр Хадгаламж банкттай байгуулсан ЗГ-015 тоот гэрээний төлбөр 888 600 000 төгрөг, "Эм Жи Эйч" ХХК 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдөр Хадгаламж банкттай байгуулсан ЗГ-013 тоот гэрээний төлбөр 3 748 100 391 төгрөг, "Эм Жи Эйч" ХХК 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдөр Хадгаламж

банктай байгуулсан ЗГ-013 тоот гэрээний төлбөр 690 281 100 төгрөг, "Баяраам" ХХК 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдөр Хадгаламж банктай байгуулсан ЗГ-016 тоот гэрээний төлбөр 3 245 394 ам долларыг, "Эрдтана" ХХК 2010 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн ЗГ-48 тоот гэрээний төлбөр 4 334 000 төгрөгийг, "Олон овоот гоулд" ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн гэрээний 3.6, 3.7-д заасныг үндэслэн дээрх зээлүүдийг батлан дааж, хариуцан төлөхөөр гэрээ байгуулсан. "Олон овоот гоулд" ХХК-ийн тухайн үеийн хувь нийлүүлэгч "Жаст групп" ХХК-ийн хувьцаа эзэмшигч Ш.Батхүүгээс лавлаж, дээрх гэрээг гаргуулах гэсэн боловч өнөөдрийг хүртэл өгөөгүй. 2009 оны 12 дугаар сарын 05-ны өдөр "Олон овоот гоулд" ХХК-ийн 50 хувийн хувьцааг худалдах тухай гэрээний нэмэлт гэрээний дагуу "Жаст групп" ХХК-ийн ерөнхий захирал Ш.Батхүү нь "Олон овоот гоулд" ХХК-ийн хувьцааны төлбөрт "Монгол газар" ХХК-ийн охин компаниуд болох "Си Ти Эр" ХХК, "Эм Жи Эйч" ХХК, "Баяраам" ХХК, "Эрдтана" ХХК-ийн дээрх өр төлбөрийг хариуцахаар болсон. Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 9 дүгээр зүйлийн 9.2-т заасныг зөрчсөн тул нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэжээ.

Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 101/ШШ2016/01139 дүгээр шийдвэрээр Иргэний хуулийн 451 дүгээр зүйлийн 451.1, 458 дугаар зүйлийн 458.1, 458.4, 153 дугаар зүйлийн 153.1, 227 дугаар зүйлийн 227.1, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн төлбөр хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д зааснаар "Олон овоот гоулд" ХХК-д холбогдох нийт 68 213 832 500 төгрөг гаргуулах, үүргийн гүйцэтгэлийг барьцааны болон хариуцагчийн бусад эд хөрөнгөөр хангуулах тухай Хадгаламж банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.12-т зааснаар нэхэмжлэгч улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдсөн болохыг дурдаж шийдвэрлэжээ.

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 689 дүгээр магадлалаар Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 101/ШШ2016/01139 дүгээр шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхиж, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.12-т зааснаар нэхэмжлэгч нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдсөн болохыг дурдаж шийдвэрлэжээ.

Нэхэмжлэгчийн төлөөлөгч хяналтын гомдолдоо: Шийдвэр, магадлалыг дараах үндэслэлээр эс зөвшөөрч гомдол гаргаж байна. Хоёр шатны шүүх хэргийг шийдвэрлэхдээ хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчиж нэхэмжлэлийн шаардлагуудыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь үндэслэлгүй. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1, 94.2, 114.1-д заасныг анхан шатны шүүх зөрчсөн. Улсын Дээд шүүхийн зөвлөмжид зөвлөлдөх тасалгааны агуулгыг тодорхойлсон. Гэтэл шүүгч өрөөндөө орж зөвлөлдсөн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил. Давж заалдах гомдолд энэ талаар дурдсан ч магадлалд "шүүх хуралдааны тэмдэглэлээс үзэхэд шүүгч зөвлөлдөхөөр гарсан нь тогтоогдсон бөгөөд шүүгчийн зөвлөлдөж байсан тасалгаанд өөр этгээд байсан, шүүгчид нөлөөлсөн гэх нөхцөл байдал хэргийн баримтаар тогтоогдоогүй тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй болно" гэж дүгнэсэн нь үндэслэлгүй. Нэхэмжлэгчээс шүүгчийн зөвлөлдөхөөр шүүх хуралдааны танхимаас гарсан тухайд маргаагүй бөгөөд харин шүүгчийн зөвлөлдөхөөр орсон тасалгаа нь хуульд заасан гадны нөлөөгүй, бодитой шийдвэр гаргах нөхцөлийг хангаагүй гэх үндэслэлээр гомдол гаргасан. Нэхэмжлэгчийн өмгөөлөгч шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцсаны дараа 2016 оны 03 дугаар сарын 01-ний өдөр шүүх хуралдааны тэмдэглэлд засвар оруулах буюу хурлын тэмдэглэлийн 14 дэх талын 3 дахь догол мөрд тухайн үед болсон үйл явдлыг үнэн зөвөөр нь бичүүлэх тухай хүсэлт гаргахад 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдөр 9067 дугаартай захирамжаар хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан. Хариуцагч нэхэмжлэлийн хувийг гардан авснаас хойш хуульд заасан хугацаанд хариу тайлбар өгөхгүй шүүх хуралдаан болдог одөр өгсөн. Мөн хариуцагчаас "Суробан" ХХК-ийн

дансны хуулга, дансны гүйлгээ үлдэгдлийн баталгаа, тайлбар, Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны нэгдүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 2022/4 дугаартай шийдвэрийг баримтыг гаргаж өгснийг шүүгч нэхэмжлэгч талд танилцуулсан ч тайлбар үгүйсгэх баримт гаргах боломжгүйгээр шүүх хуралдааныг үргэлжлүүлсэн. Манайх тайлбар гаргах шаардлагатай байсан. "Суробан" ХХК-тай холбоотой баримтуудыг тодруулах, түүнтэй холбогдолтой бусад баримтууд, дансны хуулга, түүнд бичигдсэн гүйлгээг шалгуулахаар шинжээч томилуулах хүсэлт, Л.Бадамцэцэгтэй холбоотой баримтууд, хариуцагчийн гарган өгсөн анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн магадлал, тогтоол, "МИБ" банкнаас улбаатай үүссэн "Олон овоот гоулд" ХХК-ийн өр төлбөртэй холбоотой баримтууд болон "Суробан" ХХК-ийн авлага нэрээр Хадгаламж банкинд бүртгэгдсэн "Олон овоот гоулд" ХХК-ийн төлөх үүрэгтэй өр төлбөртэй холбоотой баримтуудыг тус тус гаргаж өгөх байсан. Хэрэг маргааныг шийдвэрлэж байгаа шүүх зохигчдод эсрэг талын тайлбар, татгалзал, түүнтэй холбогдуулан гаргаж байгаа нотлох баримтыг танилцуулах, түүнтэй холбоотой тайлбарыг гаргах, өөрийн тайлбарын үндэслэлийг нотлох нотлох баримтыг гаргаж өгөх талаар танилцуулж, эрхийг нь эдлүүлснээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1-д зааснаар эрх, үүргийг нь тайлбарлан өгөх үүргээ хангалттай биелүүлэх ёстой. Зохигчид мэргэжлийн өмгөөлөгчөөс туслалцаа авч байгаа явдал нь шүүхийн хэргийн оролцогчдод эрх, үүргийг хуульд нийцүүлэн тайлбарлах, маргаан нотолгооны зүйлийг тодорхойлох үүргээс чөлөөлөгдөхгүй.

Анхан шатны шүүх "Иргэний хуулийн 281 дүгээр зүйлд заасан зээл гэдэг нь мөнгө буюу төрлийн шинжээр тодорхойлогдох эд зүйлийг захиран зарцуулах эрхтэйгээр шилжүүлэх бөгөөд хүлээн авсан этгээд тодорхой хугацааны дараа хүүтэй эсвэл хүүгүйгээр эргүүлэн өгөхийг хэлнэ. Хүлээн авсан этгээд тухайн мөнгө болон эд хөрөнгийг хэрэглэх эрхтэй бөгөөд шилжүүлж авснаар түүний өмчлөгч нь болдог. Өмчлөгч нь тухайн эд хөрөнгийг Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1-д зааснаар өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж ашиглаж захиран зарцуулах эрхтэй байдаг. Гэтэл зохигчдын хооронд байгуулагдсан дээрх зээлийн гэрээнүүдийн дагуу хариуцагчийн дансанд шилжиж орсон мөнгөн хөрөнгийг банк урьдчилж өгсөн даалгавар гэдэг үндэслэлээр захиран зарцуулсан байна..." гэж дүгнэсэн. Давж заалдах шатны шүүх "Нэхэмжлэгчийн гаргаж өгсөн талуудын байгуулсан зээлийн гэрээ, Хадгаламж банкны зээлийн дансны хуулга, зээлийн гүйлгээ хийх шийдвэр, Хадгаламж банкны гүйлгээний баримт, Хадгаламж банкны мемориалын баримт, хариуцагчийн зээл хүссэн өргөдөл, "Олон овоот гоулд" ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын тогтоол, Хадгаламж банкны зээлийн хорооны хурлын шийдвэр гэсэн баримтууд нь маргаж буй зээлийн гэрээний дагуу мөнгөн хөрөнгийг бодитой шилжүүлсэн гэж эргэлзээгүй нотлох баримт гэж үзэхэд учир дутагдалтай байна" гэж анхан шатны шүүхийн шийдвэрийг зөвтгөж дүгнэсэн. Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 3.3-д зааснаар шүүхээс маргааныг шийдвэрлэхдээ илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэх зарчимтай. Мөнгөн зээлийг банк, эсхүл эрх бүхий хуулийн этгээдээс олгох тохиолдолд Иргэний хуулийн 451-453 дугаар зүйлүүд нь илүү нарийвчилсан заалт болох бөгөөд 281-285 дугаар зүйлүүд энэ тохиолдолд хэрэглэгдэхгүй байсан. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-д зааснаар банк, эрх бүхий этгээдээс олгох зээлийн гэрээнд зээлийг ашиглах зориулалтыг тусгайлан заадаг тул зээлдэгчээс гэрээнд заасан зориулалтаас өөрөөр зээлийн мөнгөн хөрөнгийг чөлөөтэй эзэмшиж, захиран зарцуулах эрх нь хуулийн дагуу хязгаарлагддаг тул шүүхээс Иргэний хуулийн 281.1, 101.1 дүгээр зүйлүүдийг хэрэглэсэн нь үндэслэлгүй болсон. Иргэний хуулийн 451 дүгээр зүйлийн 451.3, 451 дүгээр зүйлийн 451.1, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 21 дүгээр зүйлийн 21.4-д заасны Хадгаламж банкнаас хариуцагчийн зээлийн дансанд гүйлгээг хийсэн, зээлийн дансан дахь гүйлгээ нь хариуцагчийн харилцах дансан дахь гүйлгээтэй тохирч байгаа байдал шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон. "Олон овоот гоулд" ХХК өөрийн дансан дахь мөнгөн хөрөнгөө хэрхэн зарцуулах нь тухайн компанийн бүрэн эрх юм. Банк Иргэний хуулийн 451 дүгээр зүйлийн 451.1, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-д заасны дагуу зээлийн гэрээгээр мөнгөн хөрөнгө шилжүүлэх үүргээ биелүүлсэн тул шүүх дээрх зүйлүүдийг хэрэглэх байсан. "Олон овоот гоулд" ХХК-ийн зээлийн мөнгийг авч ашиглаагүй

гэх тайлбар нь нотлох баримт. Харин банкнаас мөнгөн хөрөнгө олгосон баримтыг шүүхэд гаргаж өгсөн боловч шүүх түүнийг огт үнэлсэнгүй. Давж заалдах шатны шүүх "талуудын хооронд байгуулсан гэрээгээр банк нь зээлийн мөнгөн хөрөнгийг хариуцагчид бодитой шилжүүлсэн, үүний дагуу хариуцагч мөнгөн хөрөнгийг ашигласан, захиран зарцуулсан байх нь хэрэгт хамааралтай, ач холбогдолтой үйл баримт болно" гэж дүгнэсэн хэрнээ нэхэмжлэгчээс хариуцагчийн зээлийг захиран зарцуулсан талаарх төлбөрийн даалгавар, чекийг нотлох баримтаар гаргаж өгөөгүй гэж гомдлыг хангахаас татгалзаж шийдрэлдсэн. Гэтэл банкнаас нэхэмжлэлийн шаардлагад дурдсан зээлийн гэрээний дагуу зээлдэгчид шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг зээлдэгчээс ашиглаж байсан бусад үйл баримтыг үнэлэхгүй орхигдууллаа.

2009 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 3Г-012 дугаартай зээлийн гэрээгээр олгосон 1 750 000 000 төгрөг нь "Олон овоот гоулд" ХХК-ийн Хадгаламж банкин дахь 1700066785 тоот төгрөгийн харилцах дансанд 2009 оны 08 дугаар сарын 21-ний өдөр 450 000 000 төгрөг, 2009 оны 08 дугаар сарын 25-ны өдөр 780 000 000 төгрөг, 2009 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр 520 000 000 төгрөгөөр тус тус шилжин орсон нь дансны хуулга, гүйлгээтэй тохирч байгаагаар нотлогдсон. "Олон овоот гоулд" ХХК-ийн Хадгаламж банкин дахь 1700066785 тоот төгрөгийн харилцах дансанд орлого зарлагын гүйлгээг судлан үзэхэд зээлийн мөнгийг ашигласан нь тогтоогддог. Үүнд Хадгаламж банкнаас 2009 оны 08 дугаар сарын 21-ний өдөр зээлийн мөнгөн хөрөнгө 450 000 000 төгрөгийг шилжүүлэхэд тус дансны өмнөх үлдэгдэл 215 473.63 төгрөг байсан. 2009 оны 08 сарын 25-ний өдөр дахин 780 000 000 төгрөгийг шилжүүлэхээс өмнө өөр бусад орлого тус дансанд ороогүй. "Олон овоот гоулд" ХХК-аас 2 050 000 төгрөгийг зээлийн бүрдүүлбэр шимтгэлд төлж үлдэгдэл 447 950 000 төгрөгийг банк хоорондын гүйлгээгээр шилжүүлж захиран зарцуулсан. 2009 оны 08 дугаар сарын 25-ны өдөр зээлийн 780 000 000 төгрөгийн шилжүүлэхэд тус дансны өмнөх үлдэгдэл 215 373.63 төгрөг байсан. "Олон овоот гоулд" ХХК-аас тухайн өдөрт нь 780 000 000 төгрөгийг зарлагадан авч дансанд 215 373.63 төгрөг үлдсэн. 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдөр буцаан 780 000 000 төгрөгийг хийж нийт үлдэгдэл 780 215 373.63 төгрөг болсон. 2009 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр дахин зээлийн 520 000 000 төгрөгийг тус дансанд шилжүүлэхээс өмнө дахин өөр бусад орлого дансанд нэмж ороогүй байдаг ба "Олон овоот гоулд" ХХК нь уг зээлийн мөнгөн хөрөнгийг уурхайн үйл ажиллагаа, өмнөх хугацаанд бусдаас авч ашигласан бараа материалын төлбөр, ажилчдын хуримтлагдсан цалингийн төлбөрийг барагдуулж үлдэгдлийг өдөр тутмын үйл ажиллагаанд бүрэн ашиглаж дуусгасан. 2009 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр дахин зээлийн мөнгөн хөрөнгө болох 520,000,000 төгрөгийг шилжүүлэхэд дансны өмнөх үлдэгдэл нь 1,699,037 төгрөг байсан. Тус дансанд дараагийн орлого орох хугацаа буюу 2009 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийг хүртэл хугацаанд зээлийн мөнгийг өдөр тутмын үйл ажиллагаанд бүрэн зарцуулж дууссан буюу 137 809 төгрөгийн үлдэгдэлтэй болсон байсан.

2009 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 033 дугаартай зээлийн гэрээгээр олгосон 1 800 000 ам.долларын зээл хариуцагчийн харилцах дансанд 300 000, 1 500 000 ам.доллараар тус тус шилжин орсон нь дансны хуулга, гүйлгээтэй тохирч байна. Хариуцагчийн ам.долларын харилцах дансны гүйгээг судлан үзэхэд 2009 оны 10 дугаар сарын 09-ний өдөр зээлийн мөнгөн хөрөнгө 300 000 ам.долларыг шилжүүлэх үед дансны үлдэгдэл 116 040.48 ам.доллар, 1 500 000 ам.долларыг шилжүүлэхэд өмнөх үлдэгдэл 6 922 ам.доллар болсон ба зээлийн 300 000 ам.долларыг бүрэн зарцуулж дуусгасан байсан. 2009 оны 10 дугаар сарын 28-ны өдөр 1 500 000 ам.долларын гүйлгээ хийгдсэн. Дараагийн орлого 2009 оны 11 сарын 02-ны өдөр орсон ба тухайн үед дансны үлдэгдэл 3 172 ам.доллар болоход зээлийг бүрэн зарцуулж дуусгасан байдаг. Дээрх баримтаас дүгнэхэд хариуцагчийн тайлбар үндэслэлгүй байсан ба дансанд нь өөр бусад орлого ороогүй, өмнө нь үлдэгдэлгүй байсан нь тодорхой байна. Банк, банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд банк, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс иргэн, хуулийн этгээдийн төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбогдсон блон банк, зээлийн эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох харилцааг тус тус зохицуулсан. Гэвч шүүхээс төлбөр тооцооны гэрээний харилцааг зохицуулсан харилцааг зээл олгох харилцааг зохицуулсан зохицуулалттай хольж хэрэглэсэн нь үндэслэлгүй. Учир нь төлбөр тооцоог гүйцэтгэх зохицуулалтад зээлийн гэрээ байгуулаагүй зээлийн харилцаанд ороогүй иргэн, хуулийн этгээдийн төлбөр тооцоог гүйцэтгэх агуулга хамаардаг. Өөрөөр хэлбэл зээлийг олгосон

тухай харилцаанд эрх зүйн дүгнэлт хийхдээ тус зүйлийн 21 дүгээр зүйлийн 21.4-т заасныг баримталж зээлийн гэрээний үүргийг шаардсан нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэрлэх байтал төлбөр тооцоог гүйцэтгэх зохицуулалтыг үндэслэж буюу зээл хэлбэрээр шилжиж ирсэн мөнгөн хөрөнгийг зарцуулах талаар төлбөрийн даалгавар бичигдээгүй байхад захиран зарцуулсан гэх үндэслэлийг гаргасан нь хуульд нийцээгүй. Иргэний хуулийн 445 дугаар зүйлийн 445.5, 445.4-т заасны дагуу нэхэмжлэлийн шаардлагад дурдсан зээлийн гэрээнүүдэд талууд зээлийн мөнгөн хөрөнгийг ашиглах зориулалтыг дараах байдлаар тохиролцсон. 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 033/3 дугаартай зээлийн нэмэлт гэрээгээр олгох 10 194 255 000 төгрөгийг гэрээний 1.3-т зааснаар толохоор тохиролцож уг зориулалтыг зээлийн нэмэлт гэрээ болон зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээнүүдэд хариуцагчийн хувь нийлүүлэгчдийн 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 00Г/104 дугаартай тогтоол, Хадгаламж банкны зээлийн хорооны 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 23/07, 23/06 дугаартай шийдвэрүүдийг тус тус үндэслэн нэмж олгож буй мөнгөн хөрөнгийг дээрх гэрээнүүдэд заасан зориулалтаар зарцуулахыг урьдчилан тохиролцсоны дагуу зээлийн мөнгөн хөрөнгийн гүйлгээг хийх үүргийг банкинд бичгээр урьдчилан өгч байгаа нь Иргэний хуулийн 445 дугаар зүйлийн 445.4-т заасантай нийцсэн. Гэрээгээр нэмж олгож байгаа зээлийн мөнгөн хөрөнгийг дээрх зориулалтаар зарцуулахаар бичгээр тохиролцож байгаа нь банкинд харилцагч урьдчилан үүрэг өгсөн гэх үндэслэлтэй байсан. 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 033/003 тоот зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ, 2012 оны 012/005 тоот зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээний 2.2-д зааснаар талуудын хооронд байгуулсан 2009 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 012, 033 тоот зээлийн гэрээнүүд, тэдгээрийн нэмэлт өөрчлөлтийн гэрээнүүдийн бусад нөхцөл хэвээр хүчин төгөлдөр үйлчлэхийг дурдсан. 012 болон 033 тоот гэрээнүүдийн 3.6-д зааснаар зээлдэгч зээл болон бусад төрлийн гүйлгээ, төлбөр тооцоогоо Хадгаламж банкны харилцах дансаар гүйцэтгэхээр тохиролцсон.

Давж заалдах шатны шүүх "хэрэг хянан иашдвэрлэх ажиллагааны явцад хариуцагчийн хүсэлтээр шүүхээс шинжээч томилж дүгнэлт гаргасан байх бөгөөд уг дүгнэлтийг гаргах болсон үндэслэл болсон нотлох баримтууд зовхон нэг талын баримт байхаас гадна нэхэмжлэгч байгууллагын хуулбар үнэн дардас болон Хадгаламж банкны нягтлан бодогчийн тэмдэг дарагдсан баримтууд нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасныг хангахгүй гэж дүгнэсэн нь хуульд нийцээгүй. Шинжээч шинжилгээг хийх явцад нэмж тодруулах шаардлагатай байгаа баримтуудыг Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу ирүүлэхийг нэхэмжлэгч талд албан бичгээр мэдэгдэж байсан тул холбогдох баримтуудыг хүргүүлж байсан. Шинжээч хариуцагчаас шинжилгээ гаргахад шаардлагатай баримтуудыг гаргуулан шинжилгээ хийхэд ашигласан нь шинжээчийн дүгнэлтэд тодорхой дурдаж хавсаргасан байхад шүүхээс нэг талын баримтуудыг үндэслэн дүгнэлт гаргасан гэж үзсэн нь үндэслэлгүй. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-д зааснаар бичмэл нотлох баримтыг шүүхэд эхээр нь, хэрэв эхийг өгөх боломжгүй бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбарыг өгөх зохицуулалттай. Банкны харилцагчийн дансны гүйлгээ нь банкны санхүүгийн программд буюу цахим хэлбэрээр хадгалагддаг тул программаас хэвлэж байгаа дансны хуулга нь эх баримт болох бөгөөд тус хуулгыг өөрийн нэвтрэх эрхээр орж хэвлэсэн банкны ажилтан нь өөрийн тэмдгийг дарж баталгаажуулдаг. Хариуцагчаас зээлийн мөнгө нь түүний харилцах дансанд шилжин орсон талаар болон гэрээ, хувь нийлүүлэгчдийн хурлын тогтоолд зурагдсан гарын үсгүүдэд маргадаггүй. Мөн "Олон овоот гоулд" ХХК-ийн одоогийн 100 хувийн хувьцаа эзэмшигч Г.Алтан нь 2012 оноос тус компанийн санхүүгийн бүтцийг бүрэн хяналтдаа авсан талаар тайлбар өгдөг ч тус хугацаанаас хойш өөрийн дансанд орсон мөнгө зөвшөөрөлгүйгээр захиран зарцуулагдаж байна гэж үзсэн бол Хадгаламж банкинд энэ талаар аливаа татгалзал, мэдэгдэл ирүүлэх байтал ирүүлээгүй. "Олон овоот гоулд" ХХК-ийн бусдын өмнө хүлээх үүргийн талаар аливаа мэдээлэлгүй байсан бол 2012 оны 033/003 дугаартай зээлийн нэмэлт гэрээ, 012/005 зээлийн гэрээнд нэмэлт нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээнд бусдын өмнө хүлээсэн үүрэг болон нэмж зээлэн авч байгаа мөнгийг бусад үүрэг, өр төлбөрийг барагдуулахаар тусгаж тохиролцох үндэслэлгүй.

Хадгаламж банкны Хувь нийлүүлэгчдийн хурлын 2011 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 13 дугаартай "Хянан шалгах зөвлөлийн дарга гишүүдийг томилох тухай" тогтоолоор Г.Алтанг Хадгаламж банкны хянан шалгах зөвлөлийн даргаар, түүний эмгөөлөгч Л.Сарангэрэлийг хянан шалгах зөвлөлийн гишүүнээр 2012 оны 01 дүгээр сарын

14-ний өдрийг хүртэл хугацаагаар тус тус томилон ажиллуулж байсан Хянан шалгах зөвлөл нь Хадгаламж банкны дүрмийн 10-т зааснаар банкны дүрэм, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих эрхийг эдэлж байсан бөгөөд Г.Алтан, өмгөөлөгч Л.Сарангорэл нар нь хянан шалгах зөвлөлийн эрх үүргийг хэрэгжүүлж байсан хэрнээ банкны удирдлагууд хоорондоо үгсэн хуйвалдаж мөнгө угааж байна гэх тайлбарыг шүүхэд гаргаж байгаа нь үндэслэлгүй болохыг тэмдэглэх нь зүйтэй. Хариуцагчаас тус компанийн актив буюу эзэмшилд байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийн захиран зарцуулах эрх нь өөрийнх гэх боловч компанийн үүрэг нь биш гэх тайлбар нь үндэслэлгүй. Нэхэмжлэгчээс "Олон овоот гоулд" ХХК-д хамгийн сүүлд 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдөр байгуулагдсан 033-003, 012-005 дугаартай гэрээний дагуу зээл олгосон тухай нэхэмжлэлд дурдсан. Хариуцагч нь тус хугацаанд хамаарах буюу 2012 оны 01 дүгээр улирлын санхүүгийн тайланг 2012 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр гаргаж тайлангийн үнэн зөв болохыг захирал, ерөнхий нягтлан бодогч нар батлан гарын үсгээ зурж байсан. Тайлангийн 2.2.20 дахь мөрөнд өр төлбөрийн нийт дүнг 255 562 899 080.15 төгрөг гэж тодорхойлсон.

Өглөгийн тайлангийн Зургаа. Урт хугацаат зээл хэсгийн 4 дэх мөрөнд /Бг-323 код/ Хадгаламж банк /зээл нэгтгэсэн/-нд төлөх төгрөгийн зээлийн дүнг 22 500 000 491 төгрөг, ам.долларын зээлийн дүнг /Бг323 код/ 25 705 000 ам.доллаароор тус тус тайлагнаж тайлангийн хувийг Сангийн яам болон УТЕГ-ын УТОХГ-р тус тус баталгаажуулан хүлээлгэн өгсөн. Гэтэл захирал Г.Алтан нь тус тайланг үнэн зөв болохыг баталж гарын үсэг зурсан хэрнээ бусдын ашигласан буюу өөрийн авч ашиглаагүй, мэдээгүй гэх зээлийг санхүүгийн тайланд бүртгэсэн байдлыг шүүх анхаарч үзсэнгүй. Хариуцагчийн 2009, 2010, 2011 он тус бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайланг жилийн санхүүгийн тайлангаар баталгаажсаныг шүүх анхаарч үзсэнгүй. Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн 2013 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 8494 дүгээр захирамжтай Хадгаламж банкны нэхэмжлэлтэй "Олон овоот гоулд" ХХК-д холбогдох 59 500 000 000 төгрөгийг гаргуулах шаардлага бүхий иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Г.Алтан нь Хадгаламж банктай эвлэрлийн гэрээг байгуулж гэрээнд нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрч байсныг дурдах нь зүйтэй. Батлан даалтын гэрээгээр хүлээсэн үүргийг өөрийн урьд нь авсан зээлийн мөнгийг төлөх үүрэгт нэмж хүлээхээр талуудын тохиролцож байгаа нь Иргэний хуулийн 236 дугаар зүйлийн 236.1.3-д заасантай нийцэж байгааг шүүх анхаарсангүй. Талуудын хооронд 2011 оны 02 дугаар сарын 17-ны өдөр байгуулагдсан №12/004 дугаартай батлан даалтын гэрээг дурдаж "Баяраам" ХХК-ийн 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 016 тоот зээлийн гэрээний үлдэгдэл 3 245 394 ам.долларыг, тус өдрийн 033/002 дугаартай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээний үндэслэл хэсэгт зээлдэгчтэй байгуулсан батлан даалтын гэрээг дурдаж "Си Ти Эр" ХХК-ийн 15 тоот зээлийн гэрээний үлдэгдэл 888 600 000 төгрөг, "Эм Жи Эйч" ХХК-ийн 13 тоот зээлийн гэрээний үлдэгдэл 3 748 100 391 төгрөг, 14 тоот зээлийн гэрээний үлдэгдэл 690 281 100 төгрөг, "Эрдтана" ХХК-ийн 48/001 тоот зээлийн гэрээний үлдэгдэл 4 334 000 000 төгрөгийн үлдэгдлийг "Олон овоот гоулд" ХХК-ийн зээлийн гэрээний дагуу авсан зээлийн үлдэгдэл дээр нэмж төлөхөөр харилцан тохиролцсоны дагуу өрийг нэгтгэн дүгнэсэн 033/003 болон 12-005 дугаартай гэрээнүүдэд дахин тусгаж "Олон овоот гоулд" ХХК-ийн хувь нийлүүлэгч Ш.Батхүү, Г.Алтан нар гарын үсэг зурсан. Гэвч хариуцагчаас гаргасан "Суулд нэгтгэсэн гэрээний хувьд зээлийг хүүгүй болгож байгаа гэж хэлээд Г.Алтангаар гарын үсэг зуруулсан нь зээлийн мөнгийг авсан гэж үзэхгүй гэх аман тайлбар нь үндэслэлгүй. Учир нь аливаа гэрээний тал гэрээг уншиж танилцахгүй гарын үсэг зурах боломжгүй тэр тусам их хэмжээний дүнтэй гэрээний нөхцөлийг уншихгүй гарын үсэг зурна гэдэг нь боломжгүй. Гарын үсэг зурсан нь зээлийн мөнгийг авсан гэж үзэхгүй гэх тайлбарын тухайд гарын үсэг зурснаар зээл олгогдох харилцаа бус урьд нь олгогдсон зээлийн төлбөрийн үүргийг зээлийн гэрээний үүрэгт нэгтгэн төлөх гэж байгаа харилцаанд хамааралгүй.

Иргэний хуулийн 400 дугаар зүйлийн 400.2-д зааснаар үүрэг гүйцэтгэгчийн хариуцлагыг батлан даагч үүрэг гүйцэтгэгчтэй хамтран хариуцахаар гэрээнд заасан бол үүрэг гүйцэтгэгч үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй, эсхүл үүргээ гүйцэтгэж чадахгүй нь илт тодорхой байвал үүрэг гүйцэтгүүлэгч үүрэг гүйцэтгэхийг батлан даагчаас шаардах эрхтэй байдаг. Хэрэгт авагдсан батлан даалтын гэрээнүүдэд 2.2, 3.1-д заасны дагуу Тохиролцсоноос дүгнэж үзэхэд батлан даагч нь үүрэг гүйцэтгэгчтэй хамтран хариуцахаар гэрээнд заасан тул түүнд нөхөх хариуцлага үүссэн байна гэж үзэх үндэслэлтэй. Шүүх

зохигчдын хооронд байгуулсан №12/003 болон №033/001 тоот зээлийн гэрээгээр ямар нэг зээл олгогдоогүй, өөрөөр хэлбэл өмнөх гэрээг нэгтгэн зээлийн валютын төрлийг сольсноор гэрээг хүчин төгөлдөр гэж үзэхгүй тул нэхэмжлэгч уг гэрээний дагуу нэхэмжлэл гаргасан гэж үзэх үндэслэлгүй дүгнэлт хийсэн. Учир нь №12/003 зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээний 1.1-д зааснаар банк зээлдэгчийн хооронд 2009 оны 08 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан тоот зээлийн гэрээ, 2009 оны 12 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан 012/001 тоот зээлийн гэрээний зээлийн үнийн дүн 2 200 000 000 төгрөгөөс 224 919 999 төгрөгийг бэлэн бусаар төлүүлж үлдэгдлийг ам.доллар болгон өөрчлөх өөрчлөлт хийж талууд Иргэний хуулийн 236 дугаар зүйлийн 236.1.3-д заасны дагуу өмнөх үүргийг солихоор тохиролцсон. Анхны зээлийн гэрээгээр зээлдэгчийн дансанд зээлийн гэрээнд заасан төгрөгийг олгосон тухай дээр тайлбарласан ба 2010 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 012-002 тоот зээлийн гэрээгээр зөвхөн 012 тоот зээлийн гэрээгээр олгосон 1 750 000 000 төгрөг болон 012-001 зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах гэрээний үлдэгдэл 450 000 000 төгрөгийн зээлийн хугацааг 12 сарын хугацаагаар сунгахаар тохиролцсон ба тус гэрээний талаар хамгийн сүүлд ам.долларын зээлийг нэгтгэсэн 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 12-005 дугаартай гэрээний өмнөтгөл хэсэгт тодорхой дурдсан ба уг гэрээ нь зээлийн үүргийн дүнгийн хэмжээнд ач холбогдолгүй байсан. Зээлийн гэрээгээр олгосон төгрөгийг ам.доллараар төлөхөөр үүрэг сольж байгаа нь Иргэний хуулийн 236 дугаар зүйлийн 236.1.3-д заасантай нийцэж байгаа ба нэгэнт олгогдсон зээлийн валютын төрлийг сольсон гэрээний дагуу дахин солигдсон валютыг шилжүүлэх үүргийг зээлдүүлэгч хүлээхгүй. Шүүх "Нэхэмжлэлийн үндэслэл болох 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 12-005 дугаартай гэрээгээр нэмж олгосон гэх 18 610 605.1 ам.долларын зориулалт нь гэрээнд зааснаар МИБ банкнаас улбаатай үүссэн өр төлбөр 18 612 785.38 ам.долларын авлагыг "Олон овоот гоулд" ХХК хариуцан төлөхөөр тохиролцов гэсэн ч 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн нэхэмжлэгчийн гаргасан хариуцагчийн депозит дансны хуулганд бичигдснээр 18 612 797.64 ам.долларыг "Суробан" ХХК-ний авлага төлөв гэж зарлагын гүйлгээ хийсэн ба хэрэгт МИБ банк болон "Суробан" ХХК-тай холбоотой төлбөр авлагын баримт байхгүй гэж дүгнэсэн. "Олон овоот гоулд" ХХК нь 2010 оны 01 дүгээр сард уул уурхайн үйл ажиллагаандаа зориулан ОХУ-ын Олон улсын хөрөнгө оруулалтын банк буюу МИБ банкнаас 20 000 000 ам.долларын зээлийг нэг жилийн хугацаатайгаар авсан. Хадгаламж банк нь уг зээлийг авахад батлан даагчаар оролцсон байсан бөгөөд "Олон овоот гоулд" ХХК нь зээлээ төлөөгүйн улмаас МИБ нь батлан даалт гаргасан Хадгаламж банкны ностро данснаас 20 000 000 ам.долларыг хасаж авснаар Хадгаламж банк "Олон овоот гоулд" ХХК-аас уг дүнгээр авлагатай болсон. "Олон овоот гоулд" ХХК-аас уг авлагыг төлөхийн тулд өөрийн эзэмшлийн 16759 дугаартай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг гуравдагч этгээдэд шилжүүлэх замаар төлөхөөр тохиролцож Хадгаламж банктай 2011 оны 08 дугаар сарын 29-ний өдөр Авлага барагдуулах гэрээг байгуулсан. Тус гэрээний дагуу "Олон овоот гоулд" ХХК-аас өөрийн эзэмшлийн 16759 дугаартай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг "Суробан" ХХК-д шилжүүлэхээр 2011 оны 08 дугаар сарын 29-ний өдөр Ашиглалтын тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай гэрээ байгуулсны дагуу хариуцагчийн нэхэмжлэгчид төлөх 20 000 000 ам.долларын авлагыг "Суробан" ХХК төлөх болсон ч тусгай зөвшөөрлийг "Суробан" ХХК-ийн нэр дээр шилжүүлж чадаагүй тул "Олон овоот гоулд" ХХК нь Хадгаламж банкинд 20 000 000 ам.доллар төлөх үүрэгтэй хэвээр үлдсэн. Иймд 2012 оны 12-005 дугаартай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээнд уг төлбөрийг МИБ банкнаас улбаатай үүссэн өр төлбөр гэж тодорхойлсон ба банк уг авлагыг төлүүлэхдээ хариуцагчаас "Суробан" ХХК-ийн авлага төлөв" гэсэн гүйлгээний утгыг тодруулан тэмдэглэж дансны бичилт хийсэн. 2015 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 34532 дугаартай шүүгчийн захирамжаар хариуцагчийн өмгөөлөгчийн хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн. Нэхэмжлэгчээс 2015 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 873 дугаартай баримт хүргүүлэх тухай албан бичгээр холбогдох баримтуудыг хүргүүлсэнээр зээлийг хүсээгүй, Хадгаламж банкнаас зээл олгосныг мэдээгүй, банк дураараа манай дансанд гүйлгээ хийсэн гэх тайлбар үндэслэлгүй болох нь тогтоогдож, няцаагдаж байсан ч шүүх уг нотлох баримтуудыг үнэлсэнгүй. Өөрөөр хэлбэл банкны аливаа албан тушаалтан дангаараа зээл олгох эсэх тухай шийдвэрийг гаргадаггүй ба зөвхөн банкны дүрэм журмаар тусгайлан эрх олгогдсон гишүүдээс бүрдэх зээлийн хорооны хурлын хамтын шийдвэрээр зээл олгох эсэхийг шийдвэрлэдэг. Нөгөө талаар "Олон овоот гоулд" ХХК-ийн Хувь нийлүүлэгчдийн хурлын ООГ/104 дугаартай тогтоолд хувь нийлүүлэгч Г.Алтан

Хадгаламж банкнаас 18 610 605.10 ам.доллар, 10 194 255 000 төгрөгийн зээлийг нэмж авах зөвшөөрлийг хувь нийлүүлэгч Ш.Батхүүгийн хамтаар гаргаж гарын үсэг зурж байсан байдалд эрх зүйн үнэлэлт өгсөлгүй орхигдууллаа. Иймд дээрх үндэслэлүүдээр гомдлыг бүхэлд нь хангаж шийдвэр, магадлалд нэхэмжлэлийн шаардлагуудыг бүхэлд нь хангаж тус тус өөрчлөлт оруулж өгнө үү гэжээ.

ХЯНАВАЛ

Анхан болон давж заалдах шатны шүүх зохигчдын хооронд үүссэн гэрээний маргаанд банк, эрх бүхий этгээдээс зээл олгох талаарх Иргэний хуулийн холбогдох зохицуулалтыг хэрэглэсэн нь зөв боловч хэрэглэвэл зохих Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийг хэрэглээгүй, хэрэгт цугларсан баримтыг хуульд заасан журмын дагуу үнэлээгүй байх тул шийдвэр магадлалд өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэв.

Нэхэмжлэгч "Хадгаламж банк" ХХК дахь Банкны эрх хүлээн авагч нь хариуцагч "Олон овоот гоулд" ХХК-д холбогдуулан зээлийн гэрээний үүрэгт 68 213 832 500 төгрөг гаргуулах, үүргийн гүйцэтгэлийг барьцаа хөрөнгөөр хангуулах, барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд санхүүгийн бусад эх үүсвэрээс төлүүлэхээр шүүхийн шийдвэрт тусгуулах шаардлага гаргасныг хариуцагч татгалзаж, маргажээ.

Нэхэмжлэгч дараах зээлийн гэрээнүүд болон батлан даалтын гэрээг үндэслэж нэхэмжлэлийн шаардлагаа гаргасан байна.

1."Олон овоот гоулд" ХХК болон Хадгаламж банк 2009 оны 08 дугаар сарын 21-ний өдөр 012 тоот зээлийн гэрээ байгуулж, 1 750 000 000 төгрөгийг сарын 1,9 хувийн хүүтэй, 6 сарын хугацаагаар зээлэх зээлийн гэрээ /хх-20/

2009 оны 12 дугаар сарын 07-ны өдөр дээрх гэрээ буюу 012/001 тоот зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулснаар 660 000 000 төгрөгийг 3 сарын хугацаатай, сарын 1,9 хувийн хүүтэй нөхцөлөөр нэмж зээлэхээр тохирсон байна.

Дээрх 2 зээлийн гэрээг нэгтгэж, 2010 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр 012/003 тоот гэрээг байгуулж, үндсэн зээл 1 750 000 000 төгрөг, 660 000 000 төгрөгөөс зээлдэгчийн төлсөн 210 224 919 төгрөгийг хасаж, үлдэх 2 199 775 080 төгрөгийг тухайн үеийн /1 ам.доллар : 1318.81 төгрөг/ ханшаар 1 668 000 ам.долларын зээл гэж гэрээнд тусгасан баримт хэрэгт авагджээ.

2.2009 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 033 тоот зээлийн гэрээгээр 1 800 000 ам.долларыг сарын 1,5 хувийн хүүтэй, 6 сарын хугацаагаар зээлэх гэрээ /хх-44/

3.2010 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 47 тоот зээлийн гэрээгээр 2 876 355 554 төгрөгийг сарын 1,8 хувийн хүүтэй 24 сарын хугацаагаар зээлэх зээлийн гэрээ /хх-57/

4 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 033-003 тоот зээлийн гэрээгээр 10 194 255 000 төгрөгийг хүүгүйгээр зээлэх

5.2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 012/005 тоот зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээгээр 18 610 605 ам.долларыг хүүгүйгээр зээлэх зээлийн гэрээг тус тус үндэслэжээ.

Эдгээр гэрээг байгуулсны дараа талууд тохиролцон 2010 оны 05 дугаар сарын 28-ны өдөр 2009 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 1 800 000 ам.долларын зээлийг монгол төгрөгт шилжүүлэн 2 494 764 000 төгрөгийн зээл гэж, 2010 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр 2010 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 2 876 355 554 төгрөгийн зээлийг 2 181 000 ам.долларын зээл гэж гэрээний зүйлийг өөрчлөн гэрээнд тусгасан байна.

Нэхэмжлэгч нь батлан даалтын гэрээний дагуу дараах зээлийг "Олон овоот гоулд" ХХК хариуцах ёстой гэж үзжээ. Үүнд:

2009 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 015 тоот Хадгаламж банк болон "Си Ти Эр" ХХК-ийн хооронд байгуулагдсан зээлийн гэрээний үлдэгдэл 888 600 000 төгрөг,

2009 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 013 тоот Хадгаламж банк болон "Эм Жи Эйч" ХХК-ийн хооронд байгуулагдсан зээлийн үлдэгдэл 3 748 100 391 төгрөг,

2009 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 014 тоот Хадгаламж банк болон "Эм Жи Эйч" ХХК-ийн хооронд байгуулагдсан зээлийн үлдэгдэл 690 281 100 төгрөг,

2010 оны 04 дүгээр сарын 12, 2010 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 48/001 тоот гэрээгээр "Эрдтана" ХХК-ийн зээлийн үлдэгдэл 4 334 000 000 төгрөг,

2009 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 016 тоот зээлийн гэрээний дагуу "Баяраам" ХХК-д олгосон зээлийн үлдэх үүрэг 3 245 394.9 ам.долларыг тус тус төлж барагдуулах үүрэгтэй гэжээ.

2012 оны 03 дугаар сарын 30-ны өдөр талууд дараах байдлаар монгол төгрөгийн болон валютын зээлийг нэгтгэн дүгнэж, үүргийг тодорхойлсон байна.

Зээлийн гэрээгээр авсан монгол төгрөгийн бүх зээлийг буюу 2009 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн зээлийн гэрээний үүрэг 2 494 764 000 төгрөг, 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн "Си Ти Эр" ХХК-ийн зээл 888 600 000 төгрөг, 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн "Эм Жи Эйч" ХХК-ийн зээл 3 748 100 391 төгрөг, 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн "Эм Жи Эйч" ХХК-ийн зээл 690 281 100 төгрөг, 2010 оны 07 дугаар сарын 12-ны өдрийн "Эрдтана" ХХК-ийн зээлийн үлдэгдэл 4 334 000 000 төгрөг, бусад зээл 150 000 000 төгрөг, 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн "Олон овоот гоулд" ХХК-ийн авсан зээл 10 194 255 000 төгрөгийг нэгтгэж, нийт 22 500 000 000 төгрөгийг төлөхөөр тооцоо нийлж, гэрээ хэлбэрээр байгуулсан байна.

Мөн 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдөр валютын бүх зээлийг нэгтгэж, үүнд 2010 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн зээлийн гэрээний дагуу "Олон овоот гоулд" ХХК-д олгосон зээл 1 668 000 ам.доллар, 2011 оны 04 дүгээр сарын 12-ны зээлийн гэрээний дагуу олгосон 2 876 355 554 төгрөг буюу 2 181 000 ам.доллар, 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн зээлийн гэрээний дагуу "Баяраам" ХХК-д олгосон зээлийн үлдэгдэл 3 245 394.9 ам.доллар, 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдөр "Олон овоот гоулд" ХХК-д олгосон зээл 18 610 605 ам.долларыг тус тус нэгтгэж, нийт 25 705 000 ам.долларын зээл байгааг дүгнэж, талууд гэрээнд гарын үсгээ зуржээ.

Дээрх 2 гэрээнд "Олон овоот гоулд" ХХК-ийн өөрийн авсан болон батлан даалтын гэрээний дагуу төлөх зээл бүгд орсон, зээлийн хүүг тохироогүйгээс гадна зээлийн үнийн дүнг зохигчид маргаагүй байна. Харин хариуцагч нь зээлийн гэрээний дагуу шилжүүлсэн гэх мөнгөн хөрөнгийг банкны зүгээс "банк хоорондын гүйлгээгээр" буцаад суутгасан, зарим зээлийг гэрээний дагуу шилжүүлээгүй, банк дураараа данснаас зээлийн мөнгөн хөрөнгийг захиран зарцуулсан тул зээл олгосон гэж үзэхгүй, мөн батлан даалтын гэрээтэй холбогдох зээлийн гэрээ хүчин төгөлдөр бус болсон гэж маргаж, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй гэж үзжээ.

Хэрэгт цугларсан баримтаас үзвэл "Олон овоот гоулд" ХХК нь 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 033-003 тоот зээлийн гэрээний дагуу авсан 10 194 255 000 төгрөг, 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 012/005 тоот зээлийн гэрээнд нэмэлт зөрчлөлт оруулах тухай гэрээгээр авсан 18 610 605 ам.доллар, 2010 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн гэрээгээр авсан 2 200 000 000 төгрөг бүгд 45 491 354 932 төгрөгийг төлөх үүрэгтэй гэж үзнэ. Дээрх 3 гэрээний дагуу зээлдүүлэгч талаас гэрээгээр тохирсон мөнгөн хөрөнгийг "Олон овоот гоулд" ХХК-ийн дансанд шилжүүлсэн. "Олон овоот гоулд" ХХК нь өмнөх зээлийг төлөх болон бусад зориулалтаар зээлийн хөрөнгийг захиран зарцуулсан нь банкны дансны хуулга болон хариуцагч компанийн дансны тухай эх хийсэн баримтуудыг үндэслэн шинжээн "Глобал капитал аудит" ХХК-ийн дүгнэлтээр тогтоосон байна.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай 21 дүгээр зүйлийн 4-т зээлдэгчийн зээлийн дансанд гүйлгээ хийгдсэнээр зээлийг олгосонд тооцохыг заасан бөгөөд энэ нөхцөл хангагдсанаас гадна зээлдэгч өөрөө мөнгийг захиран зарцуулжээ.

"Олон овоот гоулд" ХХК-ийн хувь нийлүүлэгч нар 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдөр ООГ/101 тоот тогтоолоор Хадгаламж банкнаас 10 194 255 000 төгрөгийн болон 18 610 605 ам.долларын зээл авахыг зөвшөөрч, эдгээр зээлээр Хадгаламж банкт байгуулсан 2011 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн авлага барагдуулах гэрээний дагуу төлөх төлбөрийн үлдэгдэл 18 612 785 ам.доллар, Самсунг корпорацид алт ачуулахтай холбоотой үүссэн авлага 7 737 572 321 төгрөг, 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 106/216 тоот гэрээний дагуу төлөх 1 453 155 133 төгрөг, Монгол шуудан банкнаас Олон овоот төслийн санхүүжилтэнд зориулж "Монгол газар" ХХК-ийн нэр дээр авсан зээлийн үлдэгдэл 1 000 000 000 төгрөгийг төлөхөд зарцуулахаар шийдвэрлэсэн, "Олон овоот гоулд" ХХК хүсэлт гаргаж, дээрх зориулалтаар зээл олгосон, зээлдэгч захиран зарцуулсан байна. /2-р хавтас х-38/

Хадгаламж банк нь 2010 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн гэрээний дагуу 2 200 000 000 төгрөгийг зээлдэгчийн дансанд шилжүүлсэн, гэрээний зүйл нь үндэсний мөнгөн тэмдэгт тул авсан зээлээ хариуцагч буцааж өгөх үүрэгтэй гэж үзнэ.

Харин банкны зүгээс 2010 оны 09 дүгээр сарын 03-ны зээлийн гэрээгээр 2 876 355 554 төгрөгийг зээлдэгчид шилжүүлээгүй тул уг мөнгийг ам.долларт шилжүүлснээр 2 181 000 ам.долларыг болон "Баяраам" ХХК-ийн 2011 оны 02 дугаар сарын 18-ны өдөр авсан 3 245 394 ам.долларыг "Олон овоот гоулд" ХХК төлөх үндэслэлгүй талаарх шинжээчийн дүгнэлт хуульд нийцсэн тул холбогдох нэхэмжлэлийг хангах үндэслэлгүй байна. Мөн 2012 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн зээлийн гэрээг нэгтгэж дүгнэсэн баримтанд байгаа "бусад зээл 150 000 000 төгрөг"-ийн үүрэг тодорхой бус, 2009 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 33 тоот гэрээгээр 1 800 000 ам.долларыг Хадгаламж банкнаас зээлдэгчийн дансанд шилжүүлсэн боловч банк буцааж суутгасан байх эдгээр нэхэмжлэлийг хариуцагч хариуцах үндэслэлгүй байна. Зээлийн гэрээ байгуулсан боловч зээлийн мөнгийг аваагүй, ашиглаагүй тул үүрэг үүсэхгүй юм.

Түүнчлэн "Олон овоот гоулд" ХХК нь батлан даалтын гэрээний дагуу үүрэг хүлээх үндэслэлгүй байна.

Батлан даалтын гэрээ нь үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах зорилготой болохоос гадна үндсэн үүргийн байдлаас шууд хамааралтай байдаг. Үндсэн үүрэг нь хүчин төгөлдөр бус бол батлан даалтын гэрээ мөн адил хүчин төгөлдөр бус байна.

"Олон овоот гоулд" ХХК нь 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдөр Хадгаламж банкт батлан даалтын гэрээ байгуулж, 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн зээлийн гэрээний дагуу төлөх "Си Ти Эр" ХХК-ийн зээл 888 600 000 төгрөг, "Эм Жи Эйч" ХХК-ийн зээл 3 748 100 391 төгрөг, "Эм Жи Эйч" ХХК-ийн зээл 690 231 100 төгрөг, "Баяраам" ХХК-ийн зээл 3 245 394 ам.доллар, 2010 оны 07 дугаар сарын 12-ны өдрийн гэрээний дагуу төлөх "Эрдтана" ХХК-ийн зээлийн үлдэгдэл 4 334 000 000 төгрөгийг тус тус хариуцахаар үүрэг хүлээсэн боловч дээрх гэрээнүүдийн дагуу Хадгаламж банкнаас зээлдэгчид зээл олгоогүй байна.

Хэрэгт цугларсан баримт, шинжээчийн дүгнэлтээс үзэхэд эдгээр зээлдэгчид нь Зээс банкнаас шилжиж ирсэн бөгөөд Хадгаламж банк 2009 оны 08 дугаар сарын 26-ны өдөр "Си Ти Эр" ХХК, "Эм Жи Эйч" ХХК, "Баяраам" ХХК-тай зээлийн гэрээ, 2010 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр "Эрдтана" ХХК-тай тус тус зээлийн гэрээ байгуулсан, гэрээнд заасан мөнгийг зээлдэгч нарын дансанд шилжүүлсэн боловч, "Зээс банкны төлөх төлбөр" гэсэн зориулалтаар буцааж авсан байна. Зээлдэгч зээлийг захиран зарцуулаагүй, ашиглаагүй учраас зээл буцааж төлөх үүрэг үүсэхгүй.

Иймд үндсэн үүрэг болох зээлийн гэрээний дагуу үүрэг үүсээгүй тул батлан даалтын гэрээний дагуу үүрэг үүсэхгүй болно.

Нөгөө талаар шинжээчийн дүгнэлтэнд батлан даалтын гэрээтэй холбоотой дээрх зээлүүд Хадгаламж банк болон "Олон овоот гоулд" ХХК-ийн хооронд байгуулагдсан 2011 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 9 810 981 000 төгрөгийн зээлээс төлөгдсөн дансны бичилт, баримт байгааг дурдаж, 9 810 981 000 төгрөгийн зээл нь төлөгдөөгүй учраас монгол төгрөгөөр төлөх 22 500 000 000 төгрөгийн зээлийн дүн хэвээр байгаа гэсэн агуулгаар дүгнэсэн байх ба энэ талаар нэхэмжлэгч маргаагүй байв. Гэрээгээр 9 810 981 000 төгрөгийн зээл олгогдоогүй учраас нэхэмжлэгч нь батлан даалтын гэрээний дагуу нэхэмжлэлээ гаргасан байна.

Шинжээчийн дүгнэлтийн үндэслэл болсон баримтуудыг үзвэл зохигчид аль аль нь зээлийн дансны гүйлгээтэй холбоотой өөрийн баримтуудыг гаргаж өгсөн, шинжээч баримтуудыг харьцуулж, тулгаж үзсэн байх ба зохигчид баримтыг маргаагүйгээс гадна шинжээчид өгсөн зарим баримт нь хуулбар боловч хэрэгт эх хувиараа давхар байгаа, ач холбогдолтой гол баримт болох дансны гүйлгээний баримт хуулийн шаардлага хангасан тул шинжээчийн дүгнэлтийг буруутгах үндэслэлгүй гэж үзэв. Харин шинжээчийн дүгнэлт дахь эрх зүйн асуудлаар буюу хэлцлийг хүчин төгөлдөр бус, хүчин төгөлдөр бус байх магадлалтай гэх дүгнэлтүүдийг шүүх үнэлэх шаардлагагүй юм.

Нэхэмжлэлийн шаардлага дахь барьцаа хөрөнгө хүрэлцээгүй тохиолдолд санхүүгийн бусад эх үүсвэрээр төлүүлэхээр шүүхийн шийдвэрт тусгуулах гэсэн нь шаардлага бус, хуулийн асуудал тул шийдвэрлэхгүй.

Харин зээлийн гэрээний үүргийг хангуулах барьцааны гэрээний зүйл болох тусгай зөвшөөрлүүдийн хувьд "Олон овоот гоулд" ХХК-ийн бусад банкнаас авсан зээлтэй холбоотойгоор хэд хэдэн банкны хооронд дундын барьцааны гэрээ байгуулагдсан, энэ журмаар үүргээ хангуулна гэж нэхэмжлэгчийн зүгээс тайлбар гаргасан тул энэ талаар шийдвэр, магадлалд дурдах нь зүйтэй гэж үзэв.

Дээрх үндэслэлээр нэхэмжлэгчийн төлөөлөгч Ч.Аварзэдийн хяналтын журмаар гаргасан гомдлын зарим хэсгийг хангаж, шүүхийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулахаар шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэлээ.

Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176 дугаар зүйлийн 176.2.2.-т заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 689 дүгээр магадлал, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 101/ШШ2016/01139 дүгээр шийдвэрийн тогтоох хэсгийн

1 дэх заалтыг "Иргэний хуулийн 451 дүгээр зүйлийн 451.1-д заасныг баримтлан хариуцагч "Олон овоот гоулд" ХХК-аас 45 491 354 932 төгрөгийг гаргуулж Хадгаламж банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчид олгож, нэхэмжлэлээс 22 722 477 568 төгрөгийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, Иргэний хуулийн 153 дугаар зүйлийн 153.1, 175 дугаар зүйлийн 175.1, Ашигт малтмалын тухай хуулийн 52 дугаар зүйлд зааснаар **ХХК-аас зүйлээс үүргийг хангуулах эрхтэйг дурдсугай**" гэж.

2 дахь заалтын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 60 дугаар зүйлийн 60.1, Улсын төмдөгийн хуралмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д зааснаар хариуцагч "Олон овоот гоулд" ХХК-аас улсын төмдөгийн хуралмалд 227 614 724 төгрөгийг гаргуулж, улсын төмдөгийн хуралмалд оруулсугай гэж өөрчилж, шийдвэр, магадлалын бусад заалтыг хэвээр үндэслэв.


2 Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.12-т зааснаар нэхэмжлэгч улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс чөлөөлөгдсөн болохыг дурдсугай.

ТАНХИМЫН ТЭРГҮҮН

al
Х.СОНИНБАЯР

ШҮҮГЧ

al
П.ЗОЛЗАЯА





ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
МАНДАЛ-ОВОО СУМЫН
ЗАСАГ ДАРГА

Өтгөн баг, Мандал-Овоо сум, Өмнөговь аймаг, 46093,
Утас: +976 70536301

Цахим шуудан: mozdtgazar@gmail.com

2024-01-31 № 1 - 22


танай _____-ны № _____-т

АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАРТ

“Зөв Зүг” ХХК нь /РД:5015553/ Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын нутагт орших MV-019336 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайг 2020 он дуустал хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байхдаа ашигт малтмалын тухай, газрын хэвлийн тухай, байгаль орчны тухай холбогдох хууль журам тогтоолуудыг мөрдлөг болгон хүлээсэн үүргээ биелүүлж ажилласан байдаг.

Тус компани 2021-2024 онуудад олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй нь үнэн болно.

ДАРГА



Ц.САНЖАА